

**MONGOLIAN ACADEMY OF SCIENCES  
INSTITUTE OF LANGUAGE AND LITERATURE  
CENTRE FOR ALTAIC STUDIES**

# **ALTAICA IX**

**Initiator:  
Academician L.BOLD**

**Editor in chief: L.Bold (MONGOLIA)**

**Members:**

**W.I.RASSADIN (RUSSIA)  
CHOI DONG GUEN (KOREA)  
M.HASHIMOTO (JAPAN)  
A.SARKOZI (HUNGARY)  
TS.ONORBAYAN (MONGOLIA)  
CENGIZ ALYILMAZ (TURKEY)**

**Secretary: B.TUVSHINTOGS (MONGOLIA)**

**ULAANBAATAR  
2012**

DDC  
494.33  
AL-30

ALTAICA цувралын энэ удаагийн дугаарт ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, МУИС-ийн Гадаад Хэл Соёлын Сургууль, Монгол Хэл Соёлын Сургууль хамтран зохион байгуулсан “Монгол улс дахь Алтай судлал 2012” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын илтгэл, мөн Алтай судлалын чиглэлээр сүүлийн үед хийсэн судалгааны зарим дүнг хэвлэн нийтэлж байна.

Энэхүү ALTAICA цувралыг алтайн хэлтэн ард түмний түүх, соёл, хэл бичгийг сонирхогч хэн бүхэнд зориулав.

**Хаяг:**

Монгол улс  
Улаанбаатар-210351  
Жуковын өргөн чөлөө 54-А  
ШУА, Хэл зохиолын хүрээлэн  
ALTAICA сэтгүүл

**Address:**

The journal ALTAICA  
Institute Language and Literature,  
Mongolian Academy of Science.  
Zhukov avenue 54-A  
Ulanbator-210651, Mongolia

Tel: 976-11-451436  
E-mail: [altaicamon@yahoo.com](mailto:altaicamon@yahoo.com)

ISBN 978-99962-2-357-0

© Хэл зохиолын хүрээлэн, 2012  
© Алтай судлалын төв, 2012

## ГАРЧИГ

### ӨГҮҮЛЭЛ

<b>Л.БОЛД</b>	Табгач хэлний pi-tö-tshen хэмээх үгийн тухай	5
<b>В.И.РАССАДИН</b> <b>С.М.ТРОФИМОВА</b>	Была ли категория грамматического рода в монгольских языках?	26
<b>М.УУТАНБАЯР</b>	Монголын хотончуудын шашны нийлэмж ба лалын гэмшил мөргөлийн хэдэн эхийн тухай	48
<b>Б.ТҮВШИНТӨГС</b>	Алтайн нурууны зүүн бэлээр нутаглагчдын хэл, шүтлэгийн тухай	55
<b>Э.ПҮРЭВЖАВ</b> <b>Ж.ГАНБААТАР</b>	Монгол, япон хэлний харилцаа холбооны асуудалд	69
<b>О.САМБУУДОРЖ</b>	Монгол хэлний үгийн гарал ба алтайн овгийн хэлнүүдийн жишээ	103
<b>С.БАТТУЛГА</b>	Казак "Нүүдэл"-ийн үнэ цэнэ ба "Монгол oqalman"	118
<b>Ц.БАТТУЛГА</b>	Эртний түрэг, уйгурын зоос, зоосон мөнгөний тухайд	136
<b>Б.МӨНХБААТАР</b>	Күл-чурын бичээст тохиолдож буй хэдэн нэрийн тухай	153
<b>О.ОТГОНЖАРГАЛ</b>	Үйлт нэрийн -маар <sup>4</sup> , -хуйц <sup>2</sup> нөхцөлийн утгыг япон хэлтэй харьцуулах нь	163
<b>Д.А.СУСЕЕВА</b>	Об официально-деловом стиле калмыцкого языка XVIII века	172

### МЭДЭЭ

Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, хэл бичгийн ухааны доктор, профессор Бухатын Базылхан (Л.Болд)	196
Монголын алтай судлал (Б.Мөнхбаатар)	216

## CONTENT

### ARTICLES

<b>L.BOLD</b>	About the word “pi-tö-tshen” in Tabgachian	5
<b>W.I.RASSADIN</b> <b>S.M.TROFIMOVA</b>	Have got category of grammatical gender in Mongolian?	26
<b>M.UUGANBAYAR</b>	About some texts on redemption praying in Islamic and the religious syncretism Khoton's in Mongolia	48
<b>B.TUVSHINTOGS</b>	About the language and worship between people that living in the east base of Altai mountain	55
<b>E.PUREVJAV</b> <b>J.GANBAATAR</b>	The aspect in relation of Mongolian and Japanese	69
<b>O.SAMBUUDORJ</b>	On the etymology of some words of Mongolian languages and examples of the comparative study of the Altaic languages	103
<b>S.BATTULGA</b>	On migration the expense of Kazaks and “Mongolian Oralman”	118
<b>Ts.BATTULGA</b>	On some coins and coined moneys of ancient Tureg and Uighur	136
<b>B.MONKHBAATAR</b>	About some marked name on the Kūli-čur inscription	153
<b>O.OTGONJARGAL</b>	The comparison on the meaning of participial suffix -maar <sup>4</sup> , -khuits <sup>2</sup> in Mongolian to Japanese	163
<b>D.A.SUSEEVA</b>	On the formal stylistics in Kalmyk language in XVIII century	172

### NEWS

About the Profecop and Mongolian scientific famous meritorious person B.Bazilkhan (L.Bold)	196
Altaic study in Mongolia (B.Monkhbaatar)	216

**ТАБГАЧ ХЭЛНИЙ PI-TÖ-TSHEN ГЭДЭГ  
ҮГИЙН ТАЛААР ӨГҮҮЛЭХ НЬ**

(Монголчуудын үсэг бичгийн асуудалд)

Монголын соёл түүхтэй гүн холбоотой бичиг “...санаа хийгээд авиа тэмдэглэх үсгийн тогтолцоо (МХДТТ)” гэдэг үгтэй нэг язгууртай гэж үзмээр “бичэци” гэдэг үг ‘хүннүгийн албан тушаалын нэр’ (Хүннүгийн толь бичиг 2011, х.13) гэсэн утгатай, харьцангуй эрт тэмдэглэгдсэн гэж судлаачид үздэг байна. Мөн хятад дүрс үсгийг галиг болгон ашиглаж, мөн утгын орчуулгатайгаар Табгач хэлний баримт болон үлдсэн нэг үгийг академич Л.Лигети pi-tö-tshen буюу эртний хятад хэлээр бол bji-tk-ts'en ~ bütikc'in ‘бичээч’ гэж сэргээн (Лигети Л. 1969, х.236) үзээд “...үүнд түрэг хэлний тайлбар ямар ч хамаагүй. Түрэг хэлний хамгийн эртний хэлбэрүүд bitigüci, bitkaci бөгөөд bitikci гэдэг нь нэлээд саяхан үүссэн болно” (мөн тэнд) гэж тэмдэглэжээ. Нэрт академичийн сэргээсэн энэ үгийн язгуур өмнө өгүүлсэн үгтэй утга, хэлбэрийн талаар нэлээд ойролцоо байгаа бөгөөд алтай хэлний системд гол байр эзэлдэг түрэг, монгол, манж-түнгүүс хэлний хэрэглэгдэхүүнтэй уул үгийг авиазүй болон үгийн бүтэц мөн утгазүйн түвшинд харьцуулан авч үзэх нь хэл судлаачдад сонирхолтой байна.

Эртний түрэг хэл: biti- ‘вырезать, надпись, писать’, bitig ‘книга, надписать, документ’, bitigaci ‘писец’- bitigaci oylan ‘ученик’, bitigci ‘писец’, bitiglig ‘письменный, относящийся к письму’, bitiglik ‘грамотность’, bitkaci ‘писец, писарь’... (ДТС, с.103).

тэмдгээс бүтдэг утга бичигтэй харьцуулахад цөөн тэмдэгтэй, харин хэдэн арван тэмдгээс бүтдэг авианы бичигтэй жишихэд хэтэрхий олон тэмдэгтэй тул табгачийн “шинэ бичиг” гэгч нь үе үсгийн буюу авиа, үе холимог үсэг байж магадгүй гэсэн сэтгэгдлийг төрүүлж байна. Табгачууд төрөө байгуулаад бичгээ зохиосон гэх энэ мэдээ нь монголын түүхэнд төдий л сонирхолтой үзэгдэл биш харин манай түүхэнд шинэ бичиг зохиосон тухай анхны тодорхой мэдээ болж байгаагийнхаа хувьд сонирхолтой байна. Эзэн хаан “шинэ бичиг”-ийг нийтээр хэрэглэх зарлиг буулгасан гэдэг нь уул “шинэ бичиг”-ийг чухамдаа төрийн албан ёсны бичиг болгосон хэрэг биз. “Шинэ бичиг” гэж онцолж буй нь хуучин бичиг байсан гэдэг ойлголтыг бидэнд тодорхой өгч байна. Энэ мэдээнд тулгуурлаад табгачууд шинэ бичигт орохоосоо өмнө орхоны руни бичгийг хэрэглэж байсан байх (Сүхбаатар Г. 1971) гэж таамагладаг. Унгарын эрдэмтэн Рона-Таш *"Тэд (Табгач нар Л.Б) руни бичиг хэрэглэж байсныг бид мэднэ"* (Рона Таш. 1965, х.119) гэсэн байдаг.

Эдгээр эрдэмтдийн санал таамаглалыг батлах шууд баримт бидний үед уламжлагдаж ирээгүй ч монгол, түрэгийн ард түмний үсэг бичгийн уламжлалыг авч үзвэл тийм байж болох юм гэсэн сэтгэгдлийг бүрэн төрүүлж байна. Манай түүхчид эртний монголын овог аймаг, түүний дотор хүннү нарын хаанчлалын үеийн археологийн олдворын “тамга”, орхон (руни) бичгийн тэмдэгтэй таарч буй нь дээрх эрдэмтдийн санал таамаглалыг зөвшөөрөх гол үндэслэл болж байна. Шууд холбогдох баримтын тухайд гэвэл 1932 онд Киргиз улсын Ачикташ суурины орчмоос олдсон руни (орхон Л.Б) бичиг бүхий модон саваа юм. Үүнийг нэрт түрэг судлаач С.Е.Малов тайлан уншсаны гадна *“Эртний түрэгийн руни бичгийг бичих хамгийн тохиромжтой зүйл нь мод байжээ”* гэж онцлон тэмдэглэсэн байна.

Энд өгүүлсэн зүйлийг эргэцүүлэн үзвэл монгол угсаатан гэдэг нь одоо нэгэнт тодорхой болсон хүннү, жужань, сяньби, тоба зэрэг овог угсааныхан ке-мо (~му) буюу мод сийлж хэрэг явдлаа тэмдэглэж байсан гэдэг мэдээ хятад сурвалжид олонтаа дурдсан нь чухамдаа модыг ашиглан руни буюу орхон бичгээр хэрэг явдлыг тэмдэглэж байсныг хэлсэн хэрэг биз?!

## НОМЗҮЙ

- Лувсанданзан. 1990.** “Алтан товч”. Редактор Бира Ш. Уб.,
- Базылхан Б. 1984.** “Монгол-казах толь”. Уб.,
- Билигсайхан Ч. 2000.** “Эрих товчис”. Уб.,
- БРС. 1973.** “Бурятско-русский словарь”. Черемисов К.М. М.,
- Владимирцов Б.Я. 2005.** “Работы по монгольскому языкознанию”. М.,
- Владимирцов Б.Я. 1989.** “Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия”, Издание 2-е. М.,
- Дамдинсүрэн Ц. 2008.** “Монголын Нууц Товчоо”, Уб.,
- ДТС. 1969.** “Древнетюркский словарь”. Редакторы Надеяев В.М., Насилов Д.М., Тенишев Э.Р., Щербак А.М. Лен.,
- Исхаков Ф.Г.,**
- Пальмбаха А.А. 1961.** “Грамматика тувинского языка /Фонетика и морфология”. М.,
- КРС. 1965.** “Киргизско-русский словарь, I-II”. Юдахин К.К. М.,
- Лигети Л. 1969.** Табгач хэл Сяньбийн нэгэн аялгуу болох нь (орч. Л.Маналжав) – “Хэл зохиол судлал”, т-IV, fasc IX. Уб.,
- Лувсанвандан Ш. 2002.** “Монгол хэлний авиазүйн онол практикийн асуудлууд/Дөтгөөр дэвтэр”. Уб.,
- Лувсандэндэв А. 1957.** “Монгол үндэсний утга зохиолын хэл бүрэлдэн тогтсон нь”. Уб.,
- МНТ. 2001.-** Word and Suffix-Index to the Secret History of the Mongols based on the Romanized

- МХДТТ. 2008.** Transcription of L.Ligeti. Compiled by Kuribayashi H., Choijinjab., Sendai.,  
“Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь-I-V боть”. Ерөнхий редактор Л.Болд. Уб.,
- МХХХЗ. 1983.** “Монгол хэлнүүдийн харьцуулсан хэлзүй”. Редактор Лувсанвандан Ш., Болд Л. Уб.,
- Пэрлээ Д. 1961.** Хэсэг байшингийн монгол бичээс-  
“Монголын судлалын зарим асуудал”, т-3. Уб.,
- ССТМЯ. 1975** “Сравнительный словарь тунгусо-маньчжурских языков”. Ред. Цинциус В.И. Лен.,
- Сүхбаатар Г. 1971.** “Сяньби”. Уб.,
- Тодаева Б.Х. 1961.** “Дунсянский язык”. М.,
- Төмөртоого Д. 1992.** “Монгол хэлний түүхэн хэлзүй”. Уб.,
- 21-тийн тайлбар толь.,** ӨМАХХ.  
Ерөнхий редактор Цэвээндорж Д. Уб.,
- “Хүннүгийн толь бичиг”. 2011.**
- Цэвэл Я. 1966.** “Монгол хэлний товч тайлбар толь”. Уб.,
- Чоймаа Ш. 2011.** “Монголын Нууц Товчоо” /Эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлгэ/. Уб.,



**В.И.РАССАДИН, С.М.ТРОФИМОВА**

**БЫЛА ЛИ КАТЕГОРИЯ ГРАММАТИЧЕСКОГО РОДА  
В МОНГОЛЬСКИХ ЯЗЫКАХ?\***

Занимаясь лингвистикой, в особенности работая с материалами конкретных языков, исследователь не может не ощущать, что он сталкивается с разными способами видения мира, то есть способа видеть мир именно так, а не иначе, отлично от других, ближних и дальних этноязыковых сообществ.

В данной статье мы попытаемся рассмотреть некоторые представления, связанные с тем, как человек воспринимает мир, как строит модели своего взаимодействия с окружающей действительностью и отражает эти модели в родном языке. Например, категория рода для индоевропейских и семитских языков еще с древнейших времен настолько существенна, что имя существительное немислимо вне данной категории. Категория рода для этих языков является очень важной характеристикой. Различие в грамматическом роде не соответствует чему-то рациональному; мы не можем объяснить, почему, например, русские слова *стол*, *юноша*, *дядя* мужского рода, а слова *площадь*, *береза*, *книга* женского рода. Нет ошибки в устах иностранца, которая больше всего резала бы ухо, чем ошибка в роде. Но, как нам известно, не всем языкам мира свойственна грамматическая категория рода. Её не знают монгольские, тюркские, финно-угорские, тунгусо-маньчжурские и ряд других языков.

---

\* Работа выполнена при финансовой поддержке РГНФ-МинОКН Монголии №112403005a/Mon

противопоставление не выражается, поэтому имена существительные не соотносятся с мужским или женским родом.

Обобщая все вышеизложенное, можно утверждать семантическую обусловленность рода древнемонгольских имен существительных и выделять лексико-морфологическую категорию рода в древнемонгольском языке. Неоднородность морфологического значения рода, проявляющаяся в наличии истинного и фиктивного родов, обуславливает неоднородность его морфологической формы, проявляющуюся в тесном переплетении лексических и морфологических средств выражения рода. Распределение существительных по родам является мотивированным либо лексически, либо морфологически, либо лексически и морфологически одновременно. Выделенные нами лексико-морфологические средства выражения родового значения охватывают абсолютное большинство одушевленных имен существительных и позволяет говорить о системности средств выражения родового значения.

## ЛИТЕРАТУРА

1. Ардентов Б.П. Введение в языкознание. Кишинев, 1967.
2. Бобровников А. Грамматика монгольского языка. Спб., 1835.
3. Вандриес Ж. Язык. М., 1937.
4. Виноградов В.В. Русский язык. 2-е изд. М., 1972.
5. Владимирцов Б.Я. Следы грамматического рода в монгольском языке // Доклады Академии наук, 1925. С. 31-34.
6. Владимирцов Б.Я. Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия. Введение и фонетика. Л., 1929.
7. Ельмслев Л. О категориях личности-неличности и одушевленности-неодушевленности // Принципы типологического анализа языков различного строя: Сб. ст. М., 1972.
8. Ковалевский О.М. Краткая грамматика монгольского книжного языка. Казань, 1835
9. Котвич В.Л. Лекции по грамматике монгольского языка. Спб., 1902.
10. Мейе А. Введение в сравнительное изучение индоевропейских языков. М.-Л., 1938.
11. Орловская М.Н. Язык монгольских текстов XIII-XIV вв. М., 1999.
12. Попов А. Грамматика калмыцкого языка. Казань, 1847.
13. Руднев А.Д. Лекции по грамматике монгольского письменного языка, читанные в 1903-1904 академ. году. Спб., 1905. Вып. 1.
14. Санжеев Г.Д. Следы грамматического рода в монгольских языках // Вопросы языкознания. 1956, №5.
15. Цыбиков Г.Ц. Пособие к практическому изучению монгольского языка. Владивосток, 1915.
16. Шмидт Я. Грамматика монгольского языка. Перевод с немецкого языка. Спб., 1832.
17. Гарьд С. Дундад уеийн монгол хэлний бутэц, хэлбэрийн судлал. Улаанбаатар, 1997.

18. Ринчен Б. Монгол бичгийн хэлний зүй. Гутгаар дэвтэр. Хэлбэр судлал. Улаанбаатар хот, 1966.
19. Doerfer G. Beitrage zur Syntax der Sprache der Geheimen Geschichte der Mongolen, "Central Asiatic Journal", vol. I, № 4, Wiesbaden, 1955, p. 248-266.
20. Pelliot P. Le vrai nom de "Seroctan", "T'oung Pao", XXIX, Leide, 1932.
21. Одзава Сигэо. "Генте: хисси мо: кого+но: си гоби:" - То:кл гайкокуго дайгаку ронсю. Токуо, 1955, № 4, с.1-19. Area and culture studies, 4, 1959. - Tokyo university of foreign studies (Краткое резюме на англ. языке).

## МОНГОЛЫН ХОТОНЧУУДЫН ШАШНЫ НИЙЛЭМЖ БА ЛАЛЫН ГЭМШИЛ МӨРГӨЛИЙН ХЭДЭН ЭХИЙН ТУХАЙ

Монголын хотончууд өөрсдийгөө мүсүрман гэж нэрлэдэг бөгөөд (Потанин: 15-18) Күран ариун судрыг (Монголын хотон нар Хуран, Хураан гэж дуудаж байна М.У) эрт цагаас эхлэн шүтсээр ирсэн лалын шашинтан нар юм. Нөгөөтэйгүүр “арабаар унших мулла (молда) нар өтөлж бараг үгүй болсон” (Потанин:15-18) гэх буюу “хотон молда нар арабаар уншдаггүй, цээжээр дуудаж шавь нартаа цээжлүүлэн сургадаг” (Владимирцов: 265-277) “хотон нарын гол шүтээн бол Коран судрын нэгдүгээр бүлэг тэдний өөрсдийн нэрлэдгээр “Амааль–Хомааль” жинхэнэ нэр нь Аль–Фатике буюу Аллах бол ертөнцийн дээд цорын ганц бурхан (ат–гаүхид) мөн гэсэн сургаал болно, ...энэ уншлагыг “Аллихам-дэллой” гэдэг ба хотон молда нар Алихаандуу хэмээн сунжруулан нэрлэдэг” (Бадамхатан:87) гэдгээс харвал монголын хотон нарын лалын шашин нь бичгийн буюу ортодокс биш харин аман буюу хетередокс хэлбэртэйгээр түгэн тархаж өнөөг хүрсэн болох нь тодорхой байна. Энд А.Инаны “Томоохон судар номтой шашнууд аль нь ч эрт хуучны олон тэнгэртэй шашны нөлөөнөөс ангид байж чадаагүй ба шинэ дээд шашны заавар зарлигт илэрхий эрс тэрсүүд олон уламжлал, бишрэл шүтлэгийг ном судартаа зохиомжилж шашны номдоо шингээсэн, ...лалын шашныг зөвшөөн хүлээсэн түрэгүүд болон бусад овог аймаг эрт хуучны шашнаас үлдсэн олон бишрэл шүтлэг, уламжлал зан үйлийг шашиндаа оруулж энэхүү бөөгийн ёсны уламжлалын ихэнх нь лалын шашны заавар зарлиг мэтээр олон зууны турш үргэлжлэн өнөөг хүрчээ” гэж бичсэнийг (Инан: 204) дурдах хэрэгтэй юм.

Эрдэмтэд монголын хотон нарын шүтлэгийг лал, бурхны шашин болоод бөө мөргөлийн нийлэг нэгэн өвөрмөц цогцос, шашны

**Эрүүл энх, аян замын тоовуу** (Худая: 18)

*Худая нэгэн тоовуу  
Есээн нэгэн тоовуу  
Унаган нэгэн тоовуу  
Утаалган нэгэн тоовуу  
Тэрст ивгем тоовуу  
Хурмаст янгалем тоовуу  
Амаал Хумаал хүчингас тоовуу*

**Сүнсний тоовуу** (Худая: 19)

*Пирыгем нэгэн тоовуу  
Яртыгам нэгэн тоовуу  
Ялгаан ганаан тоовуу  
Ятгиан ергээн тоовуу  
Илгаан анаан тоовуу  
Унжаан аннай тоовуу  
Таскыр эргэн тоовуу*

**Бурхны өршөөл тоовуу** (Худая: 19)

*Лой эмээн алдаан сууга  
Бүрайн нэгэн тоовуу  
Эсээн нэгэн тоовуу  
Ерээн хаан тоовуу  
Есээн хаан тоовуу  
Мянгалан нэгэн тоовуу  
Юүргэн юүргэн тоовуу  
Худаа нэгэн тоовуу  
Хяргай нэгэн тоовуу  
Яртгайн нэгэн тоовуу  
Ясеан нэгэн тоовуу  
Яраа мангаан тоовуу  
Ергөө номгон тоовуу  
Астаан хурлаан тоовуу*

гэсэн байдалтай байх ажээ.

## НОМЗУЙ

1. Бадамхатан С. *Увсын хотон ястан*. Эрдэнэт. 1995
2. Владимирцов Б.Я. Турецкий народец хотоны *Записки восточного отделения Императорского русского археологического общества. том. 23*. Петроград. 1916
3. Отгон Х. *Хотон угсаатан*. Улаанбаатар. 2005
4. Потанин Г.Н. *Очерки северо-западной Монголии Путешествие 1876-1877*. вып. 2, Санкт Петербург. 1881
5. Самойлович А.Н. Турецкий народец хотоны. 2: Хотонские записки Потанина *Записки восточного отделения Императорского русского археологического общества. том 23 вып. 3/4*. Петроград. 1916
6. Санхүү Б. *Худая нийгэмлэгийн 20 жилд зориулав* Улаанбаатар 2011
7. *Худая*. Сударласан Б.Санхүү, Т.Тэсвээн, П.Лхагвасүрэн Улаанбаатар. 2005
8. Inan A. *Tarihte ve Bugun Samanizm. Materyaller ve Arastirmalar*. Ankara. 1995
9. Kokelekli. H. *Dua Zikir ve Tovbe, Insanin Allah`a Yonelisi Islam`a Giris Gencligin Islam bilgisi*. Ankara. 2006
10. Sambuudorj O. Religious syncretism and beliefs of Hoton people who live in Uvs province in Mongolia *Природные условия, история и культура западной Монголии и сопредельных регионов Тезисы докладов международной научной конференции. 18-22 сентября 2003 г., г. Ховд, Монголия* Томск. 2003
11. Senturk L., Yazici S., *Islam Imihali*. Ankara. 2005
12. Tunc C. *Tovbe hakkında bazi meseleler Ankara Üniversitesi İlahiyat Fakültesi Dergisi* 24. 1978

**АЛТАЙ НУРУУНЫ ЗҮҮН БЭЛЭЭР НУТАГЛАГЧДЫН  
ХЭЛ, ШҮТЛЭГИЙН ТУХАЙ**

Алтай нурууны зүүн бэл нь Монгол орны баруун хэсэгт хамаарагдах бөгөөд уг нутагт монгол, түрэг гаралтай ард түмэн аж төрж байна. Тэд Монгол Улсын засаг, захиргааны хуваарийн дагуу Баян-Өлгий, Говь-Алтай аймгуудад амьдардгаас Баян-Өлгий аймагт монгол угсааны дөрвөд, урианхай, түрэг угсааны тува, хасаг нар байдаг. Монгол улсын нийт хүн амын дотор хасаг 101526 (2010 он), дөрвөд 72403 (2010 он), урианхай 26654 (2010 он), тува 5169 (2010 он) хүн амтай бөгөөд хэлний хувьд монгол төрлийн хийгээд түрэг төрлийн хэл аялгуугаар ярина.

Хэлшинжлэлд монгол, түрэг хэлийг нэг гаралтай хэмээн үзэх явдал бий боловч энэ саналд эргэлзэгчид хийгээд эсэргүүцэгчид ч мөн цөөнгүй бий. Тодруулбал Полтавын тулалдааны үеэр (1709 он) Оросын армид олзлогдсон Шведийн цэргийн офицер Ф.Й.Страленберг анх Сибирь орчмын нүүдэлчдийн хэл, аялгуунууд өөр хоорондоо төстэй болохыг анзааран ажиглаж тэдгээрийг нэг гаралтай талаар санал дэвшүүлснээс хойш монгол, түрэг, манж-түнгүс хийгээд солонгос, япон хэлнүүдийг гарлын холбоотой хэмээн үзэж, тэдгээрийг Алтай овгийн хэлнүүд, өвөг хэлийг нь Алтай хэл хэмээн болзмолоор нэрлэдэг.

Судлаачид дээр дурдсан хэлнүүдийн хувьд ижил төстэй зүйл олон байдгийг онцлон тэмдэглэж ялангуяа үгийн сангийн түвшний судалгааг түлхүү хийжээ. Тухайлбал түрэг, монгол хэлний үгийн сангийн 50%, залгавар бүтээврийн 25% тохирдог гэж үзэж байна. Гэвч энэ талын судалгааг монгол хэлний талаас түлхүү ажиглаж, язгуур бүтээврийн түвшинд хийх шаардлага байсаар л байна.



хүмүүс ирсэн ч аргагүйн эрхэнд орхиод явдаг байсан гэнэ. Ингэсээр хэлмэгдүүлэлтийн үе дуусаж цаг гайгүй болон Нурчаагийн бие ч сайжирсан байна. Сайжрах төдийгүй 90 нас нэлээд өнгөрөн 1970-аад оны эхээр нас барсан гэнэ.

Хасагийн ард олны дунд хадгалагдан үлдэж тэдний нэрийн хуудас болсон соёлын нэг зүйл нь хуучны монголчуудаас уламжлалтай бүргэдээр ан бариулах заншил юм. Сурвалж бичигт тэмдэглэснээр эрт цагт монголчууд шувуугаар ан бариулж байсан нь бусад нүүдэлчин аймгуудад нөлөөлж, улмаар орчин үеийн хасагуудын дотор бүргэд тэжээх, бүргэдээр үнэг, туулай бариулах хэлбэрээр үлджээ. Жил бүрийн 10 сарын эхээр хасагууд “Бүргэдийн баяр” хэмээх тусгай наадам-үзүүлбэр зохион байгуулдаг<sup>13</sup>. Энэхүү баярынхаа үеэр бүргэдийг хэрхэн анд сургасан болон амьтан барьж байгааг голлон үзүүлдэг. Ингэхдээ уулын орой дээр сургасан бүргэдээ авч гараад нүднийх нь боолтыг аван уулын бэлд яваа үнэг, туулай, бэлтрэг зэрэг амьтан бариулна. Зарим айл бүргэдээ сургах гэж дээрх амьтдыг тэжээх нь ч бий.

Монголчууд болон хасагуудын аж төрөх хэлбэр ерөнхийдөө адилхан боловч зарим зарим зүйл дээр ялгаа гардаг нь тэдний шапин шүтлэгтэй холбоотой бололтой. Жишээ нь, хасагууд хоол идэхийн өмнө заавал Аллах бурханд залбирал үйлддэг бол урианхай, дөрвөдүүд хоол ундаа идсэний дараа “Рашаан болог” гэсэн ерөөл хэлж байна. Түүнчлэн хасагуудын дотор Рамадан сарын заншил хүчтэй хадгалагдсан хэвээр бөгөөд энэ сарынхаа үед өдөр нь хоол идэхгүй, нар жаргасны нэлээд хойно шөнөөр хоол идэх сахилыг баримталдаг.

Монгол болон хасагуудын ахуйн холбогдолтой нэгэн ялгаа нь тэдний идэшний хонь бэлдэхэд харагддаг. Нийт монголчууд хонийг өрлөж муулдаг бол хасагууд гүрээний судсыг нь тасалж цусыг нь юүлж алдаг онцлогтой. Түүнчлэн хасагууд хонины мах эвдэхдээ ууцыг нь 6 хавиргатай авч, сүүлний хоёр хэсгийг гуяны махтай нь дагуулж эвдэх ба сүүлний годонг элэгтэй нь шарж иддэг.

---


<sup>13</sup> Баян-Өлгий аймгийн Сагсай сумын төвийн урдхан байх жижигхэн уулын дэргэд хийдэг Бүргэдийн баяр нь бусад бүргэдийн баяраас хамгийн том, олон хүн хамардаг онцлогтой.

Ер нь судлаачдын үзэж байгаагаар Баруун монгол нь хасагуудын үндэстний соёл хэвээрээ хадгалагдан үлдсэн дэлхий дээрх цорын ганц нутагт тооцогдож байна.

Хавсралт №1.

Ардас алтайн шилд  
Анастай будан шайна  
Агнаау мордогсон залуу нь  
Улаан шайр дийвэр  
Чүрээт гарсан будан  
Урты цагаан будан  
Унааг мордогсон морь нь  
Усан шайр дийвэр  
Тохосог мордогсон шээл нь  
Тохон зайдалаг морон  
Тохосог мордогсон залуу нь  
Улаан шайр дийвэр  
Тохосог мордогсон тохой нь  
Тогос шувуунт орон  
Тохосог гарсан залуу нь  
Улаан шайр дийвэр  
Хазарлааг мордогсон хазар нь  
Халхи ханхайн хазар  
Хазарлааг мордогсон залуу  
Улаан шайр дийвэр  
Хамсаргалааг мордогсон хамсарга нь  
Ханди ханхайн хамсарга  
Хамсаргалааг мордогсон залуу  
Улаан шайр дийвэр  
Хударгалааг мордогсон хударга нь  
Хуи ханхайн хударга  
Хударгалааг мордогсон залуу  
Улаан шайр дийвэр  
Оломтоог мордогсон олом нь  
Олон өнгөн улаган  
Оломтоог гарсан залуу  
Улаан шайр дийвэр  
Жиртмээг мордогсон жаром нь  
Жаран толг шайдалаг  
Жиртмээг мордогсон залуу  
Улаан шайр дийвэр  
Даралааг мордогсон дарав нь  
Дам ханга хайр  
Даралааг мордогсон залуу  
Улаан шайр дийвэр

Хавсралт №2.



Хавсралт №3.

Уваан уангатай

Ээ-хээ мөнх(ө) ца-сан эх-тэй  
мөл-гөр чуллуун эр-дэнэ-тэй  
өр-гөн тү-лэн өн-дөр ху-дэр баян хан  
Ял-тай ну-таг лийм гэв гэ-хээ лоо

The image shows a musical score for the song 'Уваан уангатай'. It consists of four staves of music in a 2/4 time signature. The lyrics are written in Mongolian script below the notes. The first staff has the title 'Уваан уангатай' and the lyrics 'Ээ-хээ мөнх(ө) ца-сан эх-тэй'. The second staff has the lyrics 'мөл-гөр чуллуун эр-дэнэ-тэй'. The third staff has the lyrics 'өр-гөн тү-лэн өн-дөр ху-дэр баян хан'. The fourth staff has the lyrics 'Ял-тай ну-таг лийм гэв гэ-хээ лоо'.

**МОНГОЛ, ЯПОН ХЭЛНИЙ ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
АСУУДАЛД**

Хэл шинжлэлд алтай хэлний тухай онол, таамаглалыг шведийн хэл судлаач Ph.J.Strahlenberg<sup>1</sup> (1676-1747) анх дэвшүүлснээс хойш алтай язгуурын бүлэг хэлний бүрэлдэхүүнд ямар ямар хэлийг багтаах тал дээр судлаачид санал зөрүүтэй байдаг ч түрэг, монгол, манж-түнгүүс хэлийг ерөнхийд нь хамруулан үздэг. XX зууны эхээр финийн монголч эрдэмтэн Г.И.Рамстедт (1873-1950), оросын профессор Е.Д.Поливанов (1891-1938) тэргүүтэй эрдэмтэд солонгос, япон хэлийг алтай язгуурын хэлний бүлэгт багтаан үзэх санал дэвшүүлсэн байна. Сүүлийн үед түрэг, монгол, манж-түнгүүс хэлнүүдийг микро алтай хэл, япон, солонгос хэлийг багтаасан тохиолдолд тэдгээрийг нийтэд нь макро алтай хэлнүүд хэмээн ялган нэрлэх хандлагатай болсон байна. Нөгөө талаар алтай язгуурын гэгдэх хэлнүүдийн гарлын талаар хоорондоо холбоотойг үгүйсгэдэг эрдэмтэд ч бас бий.

Япон хэлний тухайт судалгааны бүтээлүүдийг тоймлон харвал япон хэлний гарал үүслийг нэг хэсэг эрдэмтэн алтай язгуурын хэлнүүдтэй холбон үздэг бол нөгөө хэсэг нь төвд, бирм хэлтэй, гурав дахь хэсэг нь малай-полинези язгуурын бүлэг хэлтэй гарал үүслийн хувьд холбоотой байж болох юм гэсэн таамаглал дэвшүүлсэн байдаг. Ингэж япон хэлийг хэд хэдэн бүлэг хэлтэй гарлын хувьд хамаатай байж магадгүй гэж үзэж байгаагаас харахад уул асуудал нь нэг мөр болж, эцэслэн шийдэгдээгүйг гэрчилнэ. Иймээс япон хэлийг зарим нэгэн судлаач холимог хэл (Mixed Language) хэмээн үзэх нь ч бий.

Монголын судлаачид япон хэлийг, японы судлаачид монгол хэлийг төрөлх хэлтэйгээ харьцуулан судалж буй нь нэг талаар хоёр хэлний гарлын холбоотойг нотлох, нөгөө талаар хоёр хэлний нийтлэг асуудлыг тодруулахад чиглэсэн нь тодорхой. Японы судлаачид монгол хэл, соёлыг 1900-аад оны эхэн үеэс сонирхон судлах болж,

<sup>1</sup> Ph.J.Strahlenberg. Das nord - uns östliche Theil von Europa und Asia, Stockolm, 1730

дорвитой томоохон бүтээл олныг туурвижээ. Харин монголын эрдэмтэд нэлээд хожуу 1970-аад оны сүүл үеэс монгол, япон хэлний харилцаа холбооны тухай асуудлыг хөндөж, сонирхон судалж эхэлсэн байдаг. Монголын япон судлаач эрдэмтдийн анхдагч нь хэл бичгийн ухааны доктор Г.Жамбалсүрэн (1941-2010) профессор юм. Тэрээр “Монгол, япон хэлний үйлдүүлэх хэв” (1974), “Исходный падеж в монгольском языке в сопоставлении с японским послелогом «kara»” (1974), “Страдательный залог в японском и монгольском языках” (1974), “A Comparison Between Mongolian Ablative Suffix -aas and Japanese Postposition -kara” (1975), “Сопоставление японских послелогов «GANIO» монгольскими падежными суффиксами” (1977) тэргүүтэй судалгааны өгүүлүүдийг бичиж, 1978 онд “Очерки сопоставительной грамматики японского и монгольского языков” хэмээх нэгэн сэдэвт бүтээл туурвиж хэл бичгийн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалжээ.

Сүүлийн жилүүдэд Монгол, Японы харилцаа бүх талаар өргөжин хөгжихийн хэрээр монголчууд Япон орныг сонирхон япон хэл сурч суралцах, улмаар монгол, япон хэлний холбоо хамаарлын тухай асуудлыг тодруулах, хэлний нийтлэгийн талаас хоёр хэлийг харьцуулан судалж буй залуу судлаач, эрдэмтдийн тоо жил ирэх тусам өсөн нэмэгдсээр байна. Монголын судлаачид япон, монгол хэлийг авиа зүй, үг зүй, өгүүлбэр зүй, үгийн сан зэрэг хэлний бүхий л төвшинд харьцуулан судалж эгшиг, гийгүүлэгч авианы сэлгэц, үгийн бүтэц, дэс дараа, нэр, үйлийн нөхцөл, өгүүлбэрийн бүтэц, хэлбэржилт зэрэг олон зүйлээрээ төсөөтэйг бодот жишээ баримтаар тогтоожээ.

Эл учрын үүднээс хөндөн буй сэдэвтэй шууд холбогдох монголын судлаачдын япон, монгол хэлний харилцаа холбооны талаар бичиж туурвисан судалгаа шинжилгээний бүтээл, судлаачдын үзэл онолыг тоймлон өгүүлье.

### **1. Авиа зүйн харьцуулсан судалгаа.**

Монгол, япон хэлийг авиа зүйн төвшинд тусгайлан харьцуулан судалсан томоохон бүтээл өнөө хэр гараагүй билээ. Авиа зүйн харьцуулсан судалгаа нь дагнан судлагчаа хүлээсэн нэгэн чухал

япон хэлтэй төсөөтэй байх нь мэдээжийн хэрэг мөн болохыг ихэд чухалчлан дурдсан байна. “Монгол хэл ба япон хэл” хэмээх эл бүтээлд монгол, япон хэлний үндсэн үгийг хэл зүй, хэлбэр судлалын төвшинд үгийн язгуур, дагавар бүтээврээр нь задалж харьцуулан тайлбарлажээ. Аливаа хэлний язгуур бүтээврийн судалгаа нь тухайн хэлнийхээ эртний түүхэн хөгжил, үндсэн дүр төрхийг сэргээн гаргахад хамгийн чухал эх хэрэглэгдэхүүн, үндсэн сурвалж болж өгдөг жамтай юм. Төрөл хэлнүүдийн үгийн гарлын судалгаа шинжилгээнд үгийн язгуур бүтээврийн харьцуулсан судалгаа шийдвэрлэх үүрэгтэй байдаг.

Японы эрдэмтдийн бичиж туурвисан онолын болон судалгааны бүтээлүүд нь манай судлаачдын бүтээлд нөлөөлж, япон, монгол хэлийг харьцуулан судлахад зарим талаар онол, арга зүйн гол зарчим болдог байна.

Сүүлийн жилүүдэд монгол, япон хэлийг харьцуулан судалж П.Хорлоо “Монгол хэлний хоршсон нийлэмж үг, түүнийг япон хэлэнд илэрхийлэх нь” (2003), С.Долгор “Япон, монгол хэлний дууриах үгийн харьцуулал” (2005), С.Дэмбэрэл “Япон, монгол хэлний ханзны толь бичгийн харьцуулсан судалгаа” (2009), Б.Батсайхан “Монгол хэлний нэр үгийн хамаатуулах ай, түүний утгыг япон хэлэнд илэрхийлэх нь” (2009) зэрэг сэдвээр тус тус хэл бичгийн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг хамгааллаа. Эдгээр судлаачид япон, монгол хэлийг цаашид улам нарийвчлан судлах нь маргаангүй юм.

### **Resume**

In the article, research publications regarding relation of Japanese and Mongolian language were outlined and written by Mongolian linguists.

An comparative studies regarding phonetics, grammar, syntax and lexicology of Japanese and Mongolian languages were studied by Mongolian linguists in all language aspects and changes of vowel, consonant, word structure, verb and noun condition, sentence structure, and formation were ascertained with true example and fact in together with availability of many identical things.

### НОМ ЗҮЙ

1. Амгалан Ц. Монгол япон хэлний өгөх оршихын тийн ялгалын харилцаа холбооны асуудалд. - “Altaica” Уб., 2001. №1. х.162-170.
2. Batsaikhan В. 日本語の連用節について. – “Япон хэл, соёл” (өгүүллийн эмхэтгэл).Уб., 2009. х.227-240.
3. Батсайхан Б. Япон хэлэнд хамаатуулах утга илрэх нь. –“Япон хэл, соёл” (өгүүллийн эмхэтгэл) Уб., 2009. х.193-203.
4. Долгор С. Япон, монгол хэлний дууриах үгийн утгын харьцуулал, онцлог. – “Япон хэл, соёл” (өгүүллийн эмхэтгэл) Уб., 2008. х.156-164.
5. Долгор С. Япон, монгол хэлний дууриах үгийн зарим бүтцийн тухайд. – “Япон судлал” №1. Уб., 2007. х.84-90.
6. Дэлгэрмаа А. Япон-монгол хэлний хэлцийг орчуулах арга, зарчмын судалгаа. Уб., 2011. Доктор (Ph.D)-ын зэрэг горилсон диссертаци.
7. Дэлгэрэхцэцэг Ц. Япон, монгол хэлний үйл үгийн цагаар төгсгөх хэлбэр ба байдлыг харьцуулах нь. – “Япон хэл, соёл” (өгүүллийн эмхэтгэл) Уб., 2008. х.184-199.
8. Дэлгэрэхцэцэг Ц. Япон, монгол хэлний үйлдэгдэх хэвийг харьцуулах нь. – “Япон хэл, соёл” (өгүүллийн эмхэтгэл). Уб., 2009. х.172-180.
9. Жамбалсүрэн Г. Монгол хэл шинжлэлийн онолын зарим асуудал. Уб., 1987.
10. Жамбалсүрэн Г. Монгол, япон хоёр хэлний үйлдүүлэх хэв. - “МУИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг” №49. Уб., 1974. х.163-180.
11. Jambalsuren G. A Comparison Between the Mongolian Ablative Suffix –“aac” and the Japanese Postposition “kara”. – “ХЗС” XI боть, fasc.1-24. Уб., 1975. pp.161-168.
12. Жамбалсүрэн Г. Сопоставление японских послелогов “GANIO” с монгольскими падежными суффиксами. – “ХЗС” XII боть, fasc. 1-18. Уб., 1977. х.117-148.
13. Жамбалсүрэн Г. Япон, монгол хоёр хэлний үгийг морфемоор нь анализ хийх асуудалд. – “Япон судлал” №1. Уб., 2007. х.71-82.
14. Жамбалсүрэн Г, Доржханд Ж. Япон, Монгол хэлний дэлгэрүүлэгч өгүүлбэрийн өгүүлбэр зүйн хийгээд утгазүйн өвөрмөц шинжийг

- жишсэн хэл шинжлэлийн үүднээс анализ хийх нь. – “Япон хэл, соёл” (өгүүллийн эмхэтгэл). Уб., 2008. х.151-155
15. Нямаа Д, Саяака М. Япон хэлний үйлдэгдэх хэв буюу үкэми-г орчин цагийн монгол хэлний үйлдэгдэх хэвтэй харьцуулах нь. – “МУИС-ийн Монгол Судлалын Эрдэм шинжилгээний бичиг”, №21 (220). Уб., 2003
  16. Оюунгэрэл Д. 指示詞に関するモンゴル語と日本語の対照研究. – “Япон хэл, соёл” (өгүүллийн эмхэтгэл). Уб., 2009. х.227-240
  17. Пүрэвжав Э. Монгол, япон хэлний ойролцоо язгуурт хэдэн үйл үгийн тухай. – “Mongolica”, vol.11 (32). Уб., 2001. х.98-103
  18. Пүрэвжав Э. Монгол, япон хэлний ойролцоо язгуурт хэдэн нэр үгийн тухай. – “Mongolica”, vol.XIV (35). Уб., 2004. х.162-167
  19. Пүрэвжав Э. Японы судлаачдын бүтээл дэх япон, монгол хэлний харилцаа холбооны асуудал. – “Хэл зохиол судлал” Боть. II (34). Уб., 2009. х.32-38
  20. Самбуудорж О. Монгол-япон хэлний авианы зарим нийтлэг хувьсал. – МУИС. ЭШБ. Уб., 1996, боть. 7(117), х.83-89
  21. Самбуудорж О. Монгол япон хэлний холбооны асуудалд. – “Соёл эрдэм дээд сургууль” ЭШБ. 2-р боть, 1-14-р дэвтэр. Уб., 1999. х.141-158
  22. Чулуунбаатар Л, Онон Ц. Япон, монгол хэлний өвөрмөц хэлцийн толь. Уб., 2009. х.296
  23. Хорлоо П. Япон, монгол хэлний давтсан үгийн бүтэц, утга зүйн онцлог. – “Япон хэл, соёл” (өгүүллийн эмхэтгэл). Уб., 2008. х.176-183
  24. Энхжаргал П. Япон, монгол хэлний үйлдүүлэх хэвийн харьцуулсан судалгаа. – “Япон хэл, соёл” (өгүүллийн эмхэтгэл). Уб., 2009. х.204-226
  25. Энхжаргал П. Япон хэлний “yo”, “ne” өгүүлбэр төгсгөх туслах үгийн утга монгол хэлнээ үгийн сангийн нэгжээр илрэх нь. – “Япон хэл, соёл” (өгүүллийн эмхэтгэл). Уб., 2008. х.200-230
  26. Энхсайхан Л. Япон-монгол хэлний үйлдэгдэх хэвийг харьцуулах нь. МУИС, МХСС-ийн Эрдэм шинжилгээний бичиг. 248 дугаар боть. Уб., 2005. х.91-99
  27. Эрдэнэбат Ц. Орчин цагийн монгол-ниппон хэлний үгийн сангийн зарим онцлог. – “Соёл эрдэм дээд сургууль” ЭШБ. 2-р боть, 1-14-р дэвтэр. Уб., 1999. х.198-202



**МОНГОЛ ХЭЛНИЙ ЗАРИМ ҮГИЙН ГАРАЛ БА  
АЛТАЙ ОВГИЙН ХЭЛНҮҮДИЙН ЖИШЭЭ**

*Түлхүүр үгс: Монгол хэл, үгийн гарал, авиа, утга, хот, хоол, илүү*

**0.Товч агуулга.** Зохиогч энэ өгүүлэлд монгол хэлний “хот”, “хөтөвч, хөтөл, хөтөлбөр”, “ховор, хомс (хомос)”, “үнэр, үнэс(эх), хүнс (хүнэс)”, “хямар-, хярам”, “битүү, бүтэх”, “илүү, үлэмж” зэрэг үгсийн утга, гарлын талаар өгүүлнэ. Тухайлбал “илүү, үлэмж” хэмээх хоёр үг нэг гаралтай болохыг “и” эгшгийн нугарлын хууль, үг бүтэх ёс, үгийн утгын холбоо (уялдаа), түүнчлэн нутгийн аялгуу, алтай овгийн хэлнүүдийн жишээ баримтаар тайлбарлан өгүүлэх болно.

**1. Удиртгал.** Энэ өгүүлэлд монгол хэлний дор дурдах зарим үгийн гарлыг монгол хэл, аялгуу болон манж-түнгүүс, түрэг, япон, солонгос зэрэг алтай овгийн хэлнүүдийн жишээ баримттай харьцуулан өгүүлэх юм.

Хэл шинжлэлд үгийн тухай олон тодорхойлолт буйгаас хамгийн их тархсан нэг тодорхойлолт бол үгийг хэлбэр, агуулгын нэгдэл гэх үзэл байдаг. Хэлбэр нь үгийн өнгөн бүтэц авианы тал болдог бол агуулга нь үгийн гүн бүтэц утгын тал болдог. Хэлний авиаг утгатай бус, утгыг бэхэлсэн болзмол тэмдэг гэдэг. Утгыг авиа, юм, ухан ойлгохуй гурвын харьцаа гэдэг. Иймд үгийн хэлбэр, агуулгын нэгдлийг үг гэж тодорхойлж болно. Хийсвэр үгс, хэлзүйн хэлбэрүүд ч харьцаанд орших хэлбэр, агуулгын нэгдэлтэй байдаг. Гэхдээ үгийн гарал судлалд үгийн хэлбэр (*form*), утга (*meaning*) тогтмол бус, хувьсан өөрчлөгдөж байдаг зүйл тул тэдгээрийн зүй тогтлыг олох нь чухал юм. Иймд бид энэ өгүүлэлд тухайн үзэл онолыг баримтлах болно.

хоцрох буюу үнэндээ хүний тоо илүүдэн хоцрох гэсэн утгатай байдаг. Иймд “үлэх, үлдэх” гэдэг хоёр үгийг нэг гаралтай гэж болох ба “-д” дагавар нь хэвийн дагавар байсныг харуулах жишээ гэж болно.

“Үлэмж” гэвэл “хэмжээнээс хэтэрсэн юм” гэсэн утгатай тул “хураамж, үзэмж” гэсэн үгсийн адил үйл үгээс нэр үг бүтээх “-мж” дагавартай үг болж байна. Иймд “илүү” гэвэл үйл язгуурт тэмдэг нэр бүтээх “үү < \*гүү” дагавар залгаж “битүү, явиуу” гэсэн үгсийн адил үүссэн үг болж байна. Ойрд болон буриад монголчууд “үлүү” гэж хэлдэг нь “и” эгшгийн нугарал болсон тохиолдол болох ба халх монголчууд “илүү” гэж хэлж буй нь “битүү” гэдэг үгийн адил “и” эгшгийн нугарал болоогүй тохиолдол болж байна.

Манж бичгийн хэлэнд “илүү” гэдэг үгийг “фүлү” гэж хэлдэг нь тухайн хэлэнд “и” эгшгийн нугарал болсон хэлбэр болохоос гадна алтайн овог хэлнүүдэд энэ үгийг эрт цагт “р (п)” гийгүүлэгчээр эхлэн хэлж байсны жишээ болно. Өөрөөр хэлбэл авианы  $*p-f-b > x > o$  хуультай холбогдож байна. Зарим түрэг хэлнүүдэд “том, их” гэсэн утгыг “үлкен” гэж хэлдэг байна. Тухайн үгийн утга, авианы хувьслаар үгийн гарлыг тогтоох төдийгүй хэл, аялгуунуудын холбоо, салсан он цаг зэргийг мэдэх боломжтой тул бид “и” эгшгийн нугарлын жишээгээр монгол хэл, аялгууны болон алтайн овгийн хэлнүүдийн холбоо, салсан он цаг, түүнчлэн монгол бичгийн хэл аль аялгуундаа суурилсан зэргийг таамаглаж болно.

Монгол хэлний “үлэг гүрвэл” гэдэг үгийн “үлэг” нь их багын “том гүрвэл”, тэнгэрийн “луу (лонг) гүрвэл”, эд өлгийн “өлгө гүрвэл” гэдгийн аль утгаар нь ойлгох вэ гэдэг нь бичгийн дурсгал, нутгийн аялгуунуудын баримт, монгол хэл, аялгуутай холбоотой байсан бусад хэлнүүдтэй харьцуулсан судалгааг улам нарийвчлан хийж байж тогтоох боломжтой гэж болно.

9. Дүгнэлт. Энэ бүхнээс үзвэл монгол хэлний үгийн гарлыг хэлбэр утгын талаас олон монгол хэл, аялгуу болон алтай овгийн хэлнүүдийн жишээ баримттай харьцуулан судлах нь ач холбогдолтой болох нь тодорхой байна. Үүнийг өмнө өгүүлсэн “хот”, “хөтөвч, хөтөл, хөтөлбөр”, “ховор, хомс (хомос)”, “үнэр, үнэсэх, хүнс

(хүнэс)”, “хярам, хямар-“, “битүү, бүтэх”, “илүү, үлэмж” зэрэг үгс, мөн тухайн үгтэй язгуур нэг үгсийн судалгаа харуулж байна. Тухайлбал “илүү, үлэмж” гэсэн хоёр үг нэг гаралтай болохыг “и” эгшигийн нугарлын хууль, үг бүтэх ёс, үгийн утгын холбоо (уялдаа) батлан харуулж байна. Үүнийг монгол хэл, аялгуу болон алтайн овгийн хэлнүүдийн жишээ ч нотолж байна.

### ХОЛБОГДОХ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

1. (Бадамдорж 2006) –Д.Бадамдорж. Монгол хэлний үгийн сангийн утгазүй. Уб., 2006. 324 тал.
2. (Базаррагчаа 1997) –М.Базаррагчаа. Монгол хэлний үгийн гарлыг мөшгөх нь. I-V боть. Уб., 1995. 3-5-р дэвтэр 23+711 тал.
3. (Базылхан 1977) –Б.Базылхан. Казах-монгол толь. Уб., 1977. 392 тал.
4. (Базылхан 1987) –Б.Базылхан. Монгол-казах толь. Уб., 1987. 885 тал.
5. (Баярсайхан 1997) –М.Баярсайхан, Т.Отгонтуул. Монгол-манж толь. Уб., 1997. 599 тал. Редактор. Г.Буянтогтох
6. (Бертагаев 1979) –Т.А.Бертагаев. Внутренняя реконструкция и этимология слов в алтайских языках. –“Проблемы общности алтайских языков. Л., 1979. 90-109
7. (Владимирцов 1929) –Б.Я.Владимирцов. Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия. –Л., 1929. 401 с.
8. (Гантогтох 2011) –Г.Гантогтох. Буриад аялгууны толь. Уб., 2010 (2011). 720 тал.
9. (Глускина 1950) Русско-Японский словарь. Составители А.Е.Глускина и С.Ф.Зарубин. М.,1950. 1000 с.
10. (Древнетюркский словарь 1971). –Лг., 1969. 317. 676 с.
11. (Дэлгэрмаа 2001) –Дэлгэрмаа. Монгол хэлний утга судлал. Леонингийн үндэсний хэвлэлийн хороо. 2001.
12. (Kara 1998) –Kara Cyörgy. Mongol-Magyar Szotar. Terebess Kiady. 1998.

13. (Кузьменков 1988) –Е.А. Кузьменков. К этимологии слов типа бурятского *хомор* // монгольского *ховор*. –“Лексикологические исследования монгольских языков. Улан-Удэ. 1988. 113-124
14. (Лувсанвандан 1975) –Ш.Лувсанвандан. Эртний монгол хэлний үгийн эхний тэсрэх, уруулын, чанга “п” гийгүүлэгч ба түүний цаашид хэрхэн хувирсан нь. –“Хэл зохиол”. 11-р боть. Уб., 1975. 4-9
15. (Лувсанжав 1968) –Чой.Лувсанжав, Цэ.Шархүү. Манж монгол толь бичиг. Уб., 1968.
16. (Мижиддорж 1976) –Го.Мижиддорж. Манж – монгол бичгийн хэлний харьцаа. Уб., 1976.
17. (Нансалмаа 2005) –Н.Нансалмаа. Үгийн сан судлал. Уб., 2005.
18. (Пак Чон Сика 1954) Русско-Корейский словарь. Под редакцией Пак Чон Сика. М., 1954. 1049 с.
19. (Поппе 1965) –Nicollas Poppe. Introduction to Altaic Linguistics. /= UAB. 14/, Wiesbaden. 1965. XIII + 212 pp. /= Н.Поппе. Алтай хэл шинжлэлийн удиртгал. Орчуулсан В.Энхболд, Л.Жумдаан. Уб., 1999. 274 тал./
20. (Рамстедт 1908) –Г.И.Рамстедт. Сравнительная фонетика монгольского письменного языка и халхаско-ургинского говора, СПб., 1908, 65 с.
21. (Рамстедт 1908) –Г.И.Рамстедт. Сравнительная фонетика монгольского письменного языка и халхаско-ургинского говора. СПб., 1908. 65 с.
22. (Рамстедт 1908) –Г.И.Рамстедт. Введение в алтайское языкознание. Морфология. М., 1957. 199 с.
23. (Самбуудорж 2012) –О.Самбуудорж. Монгол хэлний зарим үг хэллэгийн утга гарал. –“Эрдэм” сонин. 2012. №.3.
24. (Самбуудорж 2011) –О.Самбуудорж. Монгол-Япон хэлний холбооны асуудалд. –“Монголын Алтай судлал”. VIII. Уб., 2011. 263-277. –“Соёл-Эрдэм Дээд сургууль. ЭШБ” Уб., 1999. II. 141-158
25. (Самбуудорж 2006) –О.Самбуудорж. Монгол хэлний үгийн бүтэц, гарлыг парадигм харьцааны аргаар судлах асуудалд. –“Монгол хэл шинжлэл”. Боть X (XXXII). Уб., 2006. 74-80
26. (Самбуудорж 2002) –О.Самбуудорж. Монгол хэлний ойрд аялгууны фонемийн тогтолцоо. Уб., 2002. 171 тал.

27. (Самбуудорж 2002) –О.Самбуудорж. Монголын газар усны нэр. -Хөвсгөл, Завхан, Говь-Алтай аймаг. –“Соогэн жюкү”. (Япон хэлээр). Д.Төмөрбаатарын хамт. Токио. №9. 2002. №9. 49-67
28. (Самбуудорж 2001) –О.Самбуудорж. Монголын газар усны нэр. Баян-Өлгий, Ховд, Увс аймаг. –“Соогэн жюкү”. (Япон хэлээр). Д.Төмөрбаатарын хамт. Токио. 2001. №8. 63 – 77
29. (Самбуудорж 2001) –О.Самбуудорж. Монгол - манж хэлний дундын үгийн авиа утгын зарим онцлог. –“Алтай судлал”. Уб., 2001. №1. 142-149
30. (Самбуудорж 1996) –О.Самбуудорж. Манж хэлэнд авианы сэлгэцээр үгийн утга ялгасан жишээнүүд. –“Монгол хэл шинжлэл”. Боть II (XXIV). Уб. 1996. 120-126
31. (Самбуудорж 1994) –О.Самбуудорж. Монгол хэл аялгуу болон алтай овгийн хэлний “*ebur*” хэмээх үгийн авиа, утгазүйн хувьсал. –“Монгол-Солонгосын хамтарсан эрдэм шинжилгээ” №3. Сөүл. 1994. 231-239
32. (Самбуудорж 1994) –О.Самбуудорж. Орчин цагийн монгол хэлний зарим хэллэгийн утга үүслийг “МНТ”-ноос тодруулах нь. –“Монгол хэл бичиг”. Хөххот. 1994. 33-39, –“МНТ-ны Олон улсын бага хурлын илтгэлийн хураангуй” Уб., 1990. 73-74.
33. (Самбуудорж 1992) –О.Самбуудорж. Монгол хэлний *-musun(-mūsūn)* дагавартай хэдэн үгийн язгуурын болон дагаврын утга гарлын тухайд. –“ШУА-ийн Мэдээ”. Уб., 1992. №1. 76-78
34. (Санжеев 1930) –Г.Д.Санжеев. Маньжуро-монгольские языковые параллели. –ИАН СССР. 9, 1930. 673-708
35. (Сэцэнцогт 1987) –Сэцэнцогт. Монгол үгсийн язгуурын толь. Хөххот. 1987. 2973 тал.
36. (Төмөртоогоо 1990) –Д.Төмөртоогоо. Монгол хэлний түүхэн хэлзүйн үндэс. 1. Монгол хэлний түүхэн авианзүй. Уб., 1992. 215 тал.
37. (Төмөртоогоо 2008) –Д.Төмөртоогоо. Монгол хэлний биеийн төлөөний нэрийн гарал, бүтэц, тогтолцоо. Уб., 2008. 185 тал.
38. (Төмөртоогоо 2011) –Д.Төмөртоогоо. Монгол хэлний бичигийн дурасхалуудын үгийн бүтэцийн харьцуулсан судалгаа. Уб., 2011. 221 тал.

39. (Түвшинтөгс 2009) –Б.Түвшинтөгс. Историко-сопоставительный анализ глагольной лексики в монгольском и маньчжурском языках. Улан-Батор. 2009. 168 с.
40. (Түрэг хэл 1988). –Türkçe sözlük (Түрэг хэлний толь). Ankara. 1998. I боть 755 тал. II боть 756-1679 тал.
41. (Хашимото 1997) –М.Хашимото. Монголын нууц товчооны монгол хэлний судалгаа. Уб., 2001. 110 тал
42. (Цинциус 1949) –В.И.Цинциус. Сравнительная фонетика тунгусо-маньчжурских языков. Л., 1949.
43. (Цолоо 1987) –Ж.Цолоо. БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг. Ойрд аялгуу. 2-р боть. Уб., 1988. 943 тал.
44. (Цэвэл 1966), –Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. Уб., 1966. 911 тал. Редактор. Х.Лувсанбалдан.
45. (Шиотани 2004) –Ш.Шиотани. Монгол хэлний үгзүй ба үгсийн сангийн судлал. Уб., 2004.

### Abstract

The author focuses in this paper the origin of the following words on the methods of phonetic laws and semantic relations: “*хот* (cattle place, farm or camp of gers, city)”, “*хөтөвч* (bedpan), *хөтөл* (low mountain-pass, groom), *хөтлөх* (to lead, to drive), *хөтөлбөр* (programme)”, “*ховор* (rare), *хомс* (*хомос*) (little, rare)”, “*үнэр* (smell), *үнэсэх* (to kiss), *хүнс* (*хүнэс*) (food)”, “*хярам* (mixed drinking of milk to boiled water), *хямар*- (bustle, to be upset, distemper, conflict, for the weather to be bad, for stomach to ache)”, “*битүү* (firmly, closed, shut or covered), *бүтэх* (to be made up of), *бүтэл* (success), *бүтэн* (whole)”, “*илүү* (more), *үлэмж* (great, mach)”. For example, the author proved the origin of these two words “*илүү*, *үлэмж*” on the facts of phonetic alternation, word formation and semantic communication. And the author also proved that they have same origin with the facts of dialects of Mongolian languages and Altaic languages.

КАЗАХ “НҮҮДЭЛ”-ИЙН ҮНЭ ЦЭНЭ БА  
“МОНГОЛ ORALMAN”

*Түлхүүр үг: Монголын Казах, Казахстан, Diaspora, “Migration”, Oralman*

**1. Ямар “нүүдэл” вэ?**

Монгол улсын казахчуудын хувьд хэд хэдэн “нүүдэл”-ийн тухай ярьж болох юм. Түүний нэг нь аж төрөх ёс, ахуй амьдралтай холбоотой “нүүдэл” /*Nomadism*/. Казахчууд монголчуудын нэгэн адил эртнээс нааш мал маллаж, дөрвөн улирлыг даган, нүүдэллэн амьдарч ирсэн “нүүдэлчин” /*Nomad, Nomads*/ ард түмэн билээ. Нүүдэллэж амьдрах ёс нь тэдний аж төрөх ёс төдийгүй амьдрах ухаан, ертөнцийг үзэх үзэл, үндэсний сэтгэлгээний суурь хүчин зүйл юм.

Нөгөө нэг нь Казахстан түүхтэй холбогдох “түүхэн нүүдэл” /*Migration*/ юм. Түүхийн эрхээр Казах үндэстэн өөр өөр улс үндэстнүүдийн харьяанд орж, задрахын зэрэгцээ түүхэн нүүдлийн явцад казах “диаспора” /*Diaspora*/ гэх ойлголт бий болжээ. Энэхүү түүхэн нүүдлийн явцад Казахстан тал нутгаас гарсан Казахстан Дунд жүзийн нэг хэсэг Шинжааны нутагт ирж суурьшсан байдаг. Тэнд зуугаад жил амьдарсны дараа буюу 1860-аад оны үеэс Шинжааны Казахстанчуудын цөөхөн хэсэг нь амьдралын эрхээр тухайн үеийн Баруун Монгол буюу Ховдын нутагт нүүн ирж, суурьшин амьдарч эхэлсэн байдаг. Монголын Казахстанчуудын хувьд Шинжаанаас Баруун Монгол руу чиглэсэн энэхүү нүүдэл нь түүхэн сонголтуудын нэг байсан. Тэдний дараагийн түүхэн сонголт бол 1990-ээд оноос эхэлсэн Казахстаныг чиглэсэн “нүүдэл” байлаа. 1991 онд хуучин Зөвлөлт /ЗСБНХУ/-ийн бүрэлдэхүүнд багтаж байсан “стан”-уудын нэг болох Казахстан тусгаар тогтнолоо зарлаж, БНКаУ-ын Ерөнхийлөгч Нурсалтан

Казах нийгэмд ямар нөлөө үзүүлэх вэ гэдэг асуудал чухал юм. Энэхүү нөлөөлөл хийгээд “нүүдэл”-ийн талаарх казахчуудын хандлага зэрэг нь Монголын этник харилцаанд төдийгүй Монгол Казах үндэстний харилцаа, казахчуудын талаарх монголчуудын үзэл бодол, монголчуудын талаарх казахчуудын үзэл бодолд эерэг нөлөө үзүүлэх боломжтой юм.

**Хавсралт-1: “Oralman” хаанаас ирэв ээ? (1989-2005он) [Ока 2008:9]**

Гарч буй улс	1989-2005		Агуулга					
	Хүний тоо	Хувь	1989-1998		1999-2002		2003-2005	
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	хувь	Хүний тоо	хувь	Хүний тоо	Хувь
Үзбекстан	209.075	53.1	53.538	32.5	51.764	61.2	103.773	71.9
Орос	52.666	13.4	24.480	14.9	14.941	17.7	13.245	9.2
<b>Монгол</b>	<b>50.083</b>	<b>12.7</b>	<b>42.426</b>	<b>25.7</b>	<b>1.893</b>	<b>2.2</b>	<b>5.764</b>	<b>4.0</b>
Туркменстан	45.982	11.7	28.218	17.1	8.992	10.6	8.772	6.1
Хятад	12.652	3.2	1.360	0.8	1.699	2.0	9.593	6.6
Киргизстан	6.863	1.7	2.595	1.6	1.960	2.3	2.311	1.6
Тажикстан	6.123	1.6	5.476	3.3	502	0.6	145	0.1
Бусад	10.455	2.7	6.753	4.1	2.882	3.4	817	0.6
НИЙТ	393.899	100.	164.846	100.	84.633	100.	144.420	100.

**Хавсралт-2: “Oralman” хаанаас ирэв? (1989-2005, 2008 он)**

Гарч буй улс	1989-2005		2008	
	Хүний тоо	Хувь	Хүний тоо	Хувь
Үзбекстан	209.075	53.1	421.630	59.7
Орос	52.666	13.4	32.806	4.6
<b>Монгол</b>	<b>50.083</b>	<b>12.7</b>	<b>96.755</b>	<b>13.7</b>
Туркменстан	45.982	11.7	57.544	8.2
Хятад	12.652	3.2	65.191	9.2
Киргизстан	6.863	1.7	7.135	1.0
Тажикстан	6.123	1.6	11.476	1.6
Иран	-	-	6.090	0.9
Турк	-	-	3.373	0.5
Бусад	10.455	2.7	4.052	0.6
НИЙТ	393.899	100.0	706.052	100.0

[БНКаЗУ-ын ХНХЯ [http://www.enbek.kz/migration/migr\\_rusdetail.php?recordID=48&mintrud=1](http://www.enbek.kz/migration/migr_rusdetail.php?recordID=48&mintrud=1); Ока 2010]



### Ном зүй

1. К.Зардыхан 2003. "Нулимстай жилүүдийн намтар", Улаанбаатар хот
2. Finke, Peter 1999. "The Kazaks of Western Mongolia" *In Contemporary Kazaks: Cultural and Social Perspectives*.ed. Ingvar Svanberg, Curzon Press.
3. UNDP Kazakhstan 2006. "Status of Oralman in Kazakhstan", Almaty.
4. Oka Natsuko 2010 「同胞の「帰還」 - カザフスタンにおける在外カザフ人呼び寄せ政策- 」『アジア経済』LI-6.
5. Oka Natsuko 2008 「祖国を目指して- 在外カザフ人尾カザフスタンへの移住」岡奈津子編『移住と「帰還」 - 離散民族と故地』アジア経済研究所
6. Diener, Alexander 2003. "One Homeland or Two? : Territorialization of Identity and the Migration Decision of the Mongolian-Kazakh Diaspora," PhD dissertation, University of Wisconsin-Madison.
7. Diener, Alexander 2005. "Problematic Integration of Mongolian-Kazakh Return Migrants in Kazakhstan," *Eurasian Geography and Economics* 46(6).
8. Diener, Alexander 2009. *One Homeland or Two? : The Nationalization and Transnationalization of Mongoli's Kazakhs*. Stanford University Press.
9. Holly Barcus and Cynthia Werner 2010. "The Kazakhs of Western Mongolia: transnational migration from 1990-2008". *Asian Ethnicity*, 11:2.
10. С.Баттулга 2002. "Баруун Монгол дахь цөөнх үндэстэн Казах нийгмийн эргэн тойрондох олон улсын харилцаа ба төрийн бодлого", (Япон хэлээр) "Litl Word" сэтгүүл, №18.
11. С.Баттулга 2003. "Монголын Казах нийгэм дэх өөрчлөлт - Зах зээлийн эдийн засаг ба Казахстаныг чиглэсэн нүүдэл -", (Япон хэлээр) *Aichi Prefectural University*, "Олон улсын соёл судлал" эрдэм шинжилгээний сэтгүүл, №4.
12. С.Баттулга 2004. "Нийгэм соёлын өөрчлөлт ба Шилжин суурьшигчдын асуудал - Казахстан дахь Монголын Казахын жишээ -", (Япон хэлээр) *Aichi Prefectural University*, "Олон улсын соёл судлал" эрдэм шинжилгээний сэтгүүл, №5.

## ЭРТНИЙ ТҮРЭГ, УЙГУРЫН ЗООС, ЗООСОН МӨНГӨНИЙ ТУХАЙД

### Оршил

Эртний Түрэг, Уйгур, Киргизийн хаант улсын үед чухам ямар зоос, мөнгөн тэмдэгт хэрэглэж байсан талаар түүхийн сурвалж бичгүүдэд тодорхой тэмдэглэн үлдээсэн мэдээ баримт үгүй бололтой. Хэдийгээр бичгийн сурвалжуудад тэмдэглэгдээгүй боловч түрэг угсаат улсуудад холбогдох зоос цөөнгүй олдсоор буй нь тэдний зоос, зоосон тэмдэгт, мөнгөний онцлог, уламжлалыг тодруулан судлахад чухал эх хэрэглэгдэхүүн болж байна. Эртний түрэг угсаат улсуудад холбогдох тэдгээр зоосыг:

- Согд бичээстэй зоос,
- Руни бичээстэй зоос,
- Уйгур бичээстэй зоос хэмээн ангилж болох юм.

Монгол-Казакстан улсын хамтарсан хээрийн шинжилгээний анги 2011 онд Булган аймгийн Дашинчилэн сумын нутаг, Улаан хэрэмийн Шороон бумбагар хэмээх газар хийсэн маллага судалгааны явцад бунхант булшнаас 60 гаруй алт, мөнгөн зоос илрүүлсэн нь эртний түрэг угсаат улсуудын зоос, зоосон мөнгөний тархалт, хэрэглээг судлахад чухал хэрэглэгдэхүүн болж байна. Уг зоосон мөнгө нь Монгол нутаг дахь эртний зоос, зоосон мөнгөний судлалд төдийгүй дэлхийн эртний зоосон мөнгөний судлалд чухал байр суурь эзлэх нь дамжиггүй.

### 1. СОГД БИЧЭЭСТЭЙ ЗООС

Түрэгүүдэд холбогдох хамгийн эртний зоос нь согд бичээстэй бөгөөд баруун Түрэгийн хаант улсад холбогдогоороо ихээхэн онцлогтой. Эртний Түрэгийн хаант улсад холбогдох зоосны хамгийн баян цуглуулга Узбек (уг нь Өзбек гэж бичих нь зөв боловч хэвшсэн

**Хоёрдугаар зоос:**

Дундаа дөрвөлжин нүхтэй, нүүр талдаа дөрвөлжин тойруулан дөрвөн хэсэг болгож уйгур бичээс бичсэн, ар талдаа ямар нэгэн бичиг болон тамгагүй цулгуй хүрэл зоос буй.

Зоосны нүүр талд бичээсийг

1. ᠶᠳᠤᠬ
2. у(а)rl(ᠶ)γ
3. уorᠶs
4. -un хэмээн дөрөв хуваан бичсэн ажээ.

Бичээсийг монгол хэлнээ буулгавал:

1. Ариун
2. зарлиг(-аар)
3. явцгааг
4. -тун хэмээсэн утгатай болно.

Дээрх мэдээ баримтаас үзэхэд эртний түрэг угсаат улсууд зоосон мөнгө хэрэглэж байсан нь тодорхой ажээ. Харин тэдгээр зоос дээрх зураг, дүрслэл, бичиг зэргийг харгалзан

1. Харь гүрний нөлөө бүхий (харьд дэлдүүлсэн зоос),
2. Харь гүрний нөлөө ороогүй зоос хэмээн ангилж болохоор байна.

Харь гүрний нөлөө орсон зоосыг дотор нь

- Византын эзэнт гүрэн (II. Justianos (565-578) хааны үед дэлдсэн)-ий нөлөө бүхий зоос
- Нангиадын ((開元遺寶 kài yuán tōng bǎo) (順天元寶 shùn tiān yuán bǎo) ) нөлөө бүхий зоос хэмээн хуваан үзэж болох юм.

Византын нөлөө орсон зоос нь баруун Түрэгийн хаант улс, харин нангиадын нөлөө орсон зоос нь зүүн Түрэг болон Уйгурын үед холбогдож буйгаараа онцлогтой юм.

Харин харь гүрний нөлөө ороогүй зоос гэдэгт харь хүний дүрс, бичиг, бэлгэдэл тэргүүт элдэв зүйлгүй руни, согд, уйгур бичигтэй, түрэг угсаатанд холбогдох тамгатай зоосуудыг хамруулж байна.

**Баруун Түрэгийн Хаант улсад холбогдох зооснууд<sup>32</sup>**



*Ташкентэд дэлдсэн “Ябгу” цол бүхий зоос*



*Византын эзэн хаан II. Justinianos (565-578) дэлдүүлсэн зоос*



*Самаркандад дэлдсэн “Хатан” цол бүхий зоос*

---

<sup>32</sup> Gaybullah Babayar, Batı Köktürk sikelerini özdeşleşme ve darp tutarlılığını belirlemede kullanılan metodlar üzerine, - Ötüken'den İstanbul'a Türçenin 1290 Yılı (720-2010) [From Ötüken to İstanbul, 1290 Years of Turkish (720-2010) ], İstanbul, 2011, pp.331-332.

Тохарт дэлдсэн зоос





Уйгур бичээст зоос<sup>33</sup>



Руни бичээст зоос<sup>34</sup>



Монгол нутгаас олдсон руни бичигт зоос<sup>35</sup>



<sup>33</sup> O.F.Sertkaya, Uyğurların Uyğur harflı sikkeleri, -Eski Türklerde Para, İstanbul, 2006.

<sup>34</sup> O.F.Sertkaya, Uyğurların Uyğur harflı sikkeleri, -Eski Türklerde Para, İstanbul, 2006.

<sup>35</sup> С.Г.Кляшторный, Монета с рунической надписью из Монголии, -Туркологический сборник 1972, Москва, 1973, стр.335-338.

**КҮЛ-ЧУРЫН БИЧЭЭСТ ТОХИОЛДОЖ БУЙ  
ХЭДЭН НЭРИЙН ТУХАЙ**

Монгол улсын нутаг дэвсгэрт оршин тогтнож, төр улсаа байгуулж асан түрэгийн хаант улс Төв Азийн нүүдэлчдийн түүхнээ томоохон байр суурь эзэлдэг билээ.

Манай эриний 552-745 оны хооронд үүсэн буй болж, хөгжил цэцэглэлтийнхээ оройд хүрч чадаж байсан түрэгүүдийн соёлын нэг томоохон амжилт бол гучин найман (есөн) үсэг зурлагаас бүрдсэн авианы бичиг хэрэглэж байсан явдал юм. Энэ бичгийг судалгааны бүтээлүүдэд руни бичиг, орхон енисейн бичиг, орхон бичиг гэх зэргээр нэрлэдэг бөгөөд уг бичгээр бичиж үлдээсэн дурсгалаар манай орон хамгийн баялаг билээ. Тухайлбал, уул бичгийн хамгийн том, хамгийн алдартай сонгодог дурсгалууд болон олон арван бага бичээс үлдэн хоцорчээ.

Руни бичгийн эдгээр дурсгалыг XVII зууны сүүл хагасаас өнөөдрийг хүртэл гадаад дотоодод судлан шинжилж, дэлхий дахины олон хэлээр ном зохиол, өгүүлэл илтгэл, шүүмж тэмдэглэл хэвлэгдэн гарсаар байна.

Хэдийгээр руни бичгийн дурсгалын судлал ийнхүү амжилттай хөгжиж буй боловч бас цааш нь гүнзгийрүүлэн судалмаар олон арван шийдвэрлэгдээгүй, маргаантай асуудал байсаар байна. Тэр ч атугай урьд өмнө судлан шинжлээд, магадлан тогтоочихсон хэмээн үзэж буй зарим бичгийн судалгаанд ч цаашид нарийвчлан үзүүштэй зүйл олон байна.

Олонх судлаачдын үзэж буйгаар бол Төв Азийн нүүдэлчдийн түүх, хэл соёлыг судлах харьцангуй эртний, эрдэм шинжилгээний хувьд нэлээд найдвартай хэрэглэгдэхүүн болсон энэхүү түүхэн

**qariyqa : täzikkä : tägip : sü / // / / / a : qazyanti : toquz  
oyuzqa : yäti : süñüsdükdä**

орчуулга:

*...и тэнд(ээсээ) гэдрэг (баруун тийш) буцан, Инчү голыг гатлан, Төмөр хаалга Тажикт хүрч цэрэг...а, эзэмшив. Есөн огузтай долоон (удаа) дайтах үед*

Бичээст тохиолдож буй “Төмөр хаалга” гэх энэ нэр Күл-тегин, Билгэ хаан, Тоньюкукийн гэрэлт хөшөөний бичээснээ тохиолддог билээ. Энэ нь эртний гайхамшигт хот болох Самаркандын өмнө байх хаалга юм хэмээн эрдэмтэд санал нэгтэй үздэг байна.

Энэ үгийн “самар” гэдэг нь “жимс” гэсэн утгатай үг бөгөөд монгол хэлний самар гэх нь угтаа “үр, жимс” гэх үгнээс гаралтай байж болох юм. Харин “кент” гэдэг нь перс хэлний “хот, балгад” гэсэн үг ажээ. Үүнээс үзэхэд тэр үед түрэгүүд одоогийн Узбек улсын Самарканд хот хүртэл цэрэглэн тулалдсан байж болох юм.

### Дүгнэлт

Монгол нутаг дахь эртний түрэг, уйгур угсаат улсуудад холбогдох бичгийн дурсгалын нэрсийн тал дээр нэлээдгүй судалгаа хийгдсэн байдаг ч Күл-чурын гэрэлт хөшөөний бичээсийн нэрсийг тухайлан судалсан нь хараахан үгүй, харин зарим нэг эрдэмтдийн бүтээлд цухас дурдсан байна. Бид уул гэрэлт хөшөөний бичээст тохиолдож буй нэрсийн дотроос газар ус, хот балгад, овог аймгийн нэрсийг түүж, түүнд тайлбар хийхийг зорьсон болно.

Уул нэрсийг цаашид нарийвчлан судлах нь эртний түрэг угсаатны төдийгүй Төв, Дундад, Зүүн хойт Азийн эртний улсуудын нийгмийн байгуулал, засаг захиргааны тогтолцоо, гадаад, дотоод харилцаа мөн түүнчлэн түүх соёл, тухайн үеийн түүхэн хэрэг явдлыг тодруулахад үлэмж чухал ач холбогдолтой болох нь гарцаагүй юм.

Күл-чурын гэрэлт хөшөөний бичээсийг зөвхөн нэрийн тухайд биш ерөнхийд нь зөв уншиж галигласнаар Орхон бичгийн дурсгалын үгийн сан, хэлзүйг улам гүнзгийрүүлэн судлахад зайлшгүй харгалзан үзэх чухал зүйл хэмээн бодно.



## НОМЗҮЙ

1. Болд Л., БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Уб., 1990.
2. Болд Л., “Орхон бичгийн дурсгал-II”, Уб., 2006.
3. БНМАУ-ын түүх, Тэргүүн боть, Уб., 1981.
4. Древнетюркский словарь, Л., 1969.
5. Kültür Bakanlığı “Karşılaştırmalı Türk lehçeleri sözlüğü I” Ankara., 1991.
6. Rachewiltz I. de, Index to the Secret History of the Mongols, Bloomington., 1972.
7. Радлов В.В., “Опыт словаря тюркских наречий”, т.Ш, ч. I, СПб., 1905.
8. МХДТТ., Ерөнхий редактор. Болд Л., “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”. V боть, Уб., 2008.
9. Сумьяабаатар Б., Нарангэрэл Б., “Монголын нууц товчооны толь”, Уб., 2008.
10. Цэцэнцогт Ш., “Монгол үгсийн язгуурын толь”, Уб., 1988.
11. Шинэхүү М., “Тариатын Орхон бичгийн шинэ дурсгал”, Уб., 1975.
12. Шинэхүү М., Орхон-Сэлэнгийн руни бичгийн шинэ дурсгал, -Археологийн судлал, Tom.VIII, fasc.1, Уб., 1980.

**ҮЙЛТ НЭРИЙН -маар<sup>4</sup>, -хуйц<sup>2</sup> НӨХЦӨЛИЙН УТГЫГ  
ЯПОН ХЭЛТЭЙ ХАРЬЦУУЛАХ НЬ**

Үйлийн тодотгон холбох нөхцөл буюу уламжлалт нэр томъёогоор бол үйлт нэрийг олон эрдэмтэд судалж ирсэн бөгөөд монгол хэлний судалгаа шинжилгээний ном зохиол, хэл зүйн бичгүүдэд энэ бүлэг нөхцөлийн үндсэн хувилбарын тоог 5-9-ийн дотор багтаан үзсээр ирсэн байна. Үүнээс үзэхэд эрдэмтэд нэр үгийг үйл үгээр тодотгохын зэрэгцээ бас өгүүлбэрт эцсийн өгүүлэхүүний үүрэг гүйцэтгэдэг эдгээр бүтээврүүдийн талаар ихээхэн санал зөрүүтэй нь харагддаг. Тухайлбал, Зөвлөлтийн эрдэмтэн профессор Г.Д.Санжеев -маар (-мээр, -моор, -мөөр)—ыг боломж заасан үйлт нэрийн нөхцөл гэж үзэн зургаан зүйл харьцаа заах хэлбэр болгожээ. Академич Ш.Лувсанвандан 1961 онд хэвлүүлсэн “Орчин цагийн монгол хэл” гэдэг бүтээлдээ -маар (-мээр, -моор, -мөөр)—ыг үйлт нэрд эс оруулан -хуйц, -хүйц-ийг үйл байдлын ирээдүйд гүйцэтгэж чадахуйц чанарыг заасан үйлт нэр гээд бас зургаан хэлбэр болгосон байна. Харин Ж.Надмид, Ц.Цэдэндамба нар долоон хэлбэртэй гэжээ.<sup>1</sup> Харин сүүлийн үед манай улсад хэвлэгдсэн монгол хэл зүйн ихэнх ном зохиолд монгол хэлний үйлт нэр нь ирээдүй цагийн -х, өнгөрсөн цагийн -сан (-сэн, -сон, -сөн), давтан болохыг заадаг -даг (-дэг, -дог, -дөг), өнгөрөн үргэлжилж байгаа цагийн -аа (-ээ, -оо, -өө), одоо цагт үйлдэгчийг заасан -гч ирээдүйд болох боломжийг заасан -маар (-мээр, -моор, -мөөр), -хуйц (-хүйц) нөхцөл бүхий долоон хэлбэртэй гэсэн байна.

Ийнхүү тодотгон холбох нөхцөлд сүүлд нэмж оруулсан, бусад нөхцөлтэй харьцуулбал бүтээлч биш хэрэглэгддэг -маар (-мээр,

<sup>1</sup> Орчин цагийн монгол хэлний үг зүйн байгуулал. Уб., 1987, Ред. Ш.Лувсанвандан

我々は毎年家畜に足りるほどの量の草と飼料をいつも準備する。/хүрэлцэх хэмжээний/ (Озава Шигэо. Монгол хэлийг дөрвөн гарагт. Токио., 1986, х.152-153)

“-хуйц, -хуйц” нөхцөлийн утгаар хэрэглэгдэж буй япон хэлний энэхүү ~ほど、くらい、ぐらい—нь бүгд байдлын хир хэмжээг заах дайвар үг юм. Үгүйсгэсэн үг хэллэг ардаа авбал “шиг мэт” (ほど、ほどの) -ийн илэрхийлэх хэмжээнд арын өгүүлбэрийн илэрхийлэх хэмжээ хүрэхгүй гэсэн санааг илэрхийлнэ. Жишээлбэл:

Чиний бодож байгаа шиг хэцүү зүйл биш.

あなたが考えているほど、難しいものではありません。

Энэ асуудал бол тэр эрэгтэй ч тайлж чадахааргүй хэцүү юм шиг байна.

この問題は、彼にも解けないくらい難しいそうだ。

Энэхүү “-хуйц, -хуйц” нөхцөл нь өгүүлбэр үл төгсгөх бөгөөд ард нь туслах үүрэгтэй үйл үг, чимэг үг ховор тохиолдоно.

## ДҮГНЭЛТ

Бид өөрсдийн задлан үзсэн багаахан баримтан дээр тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. “-маар<sup>4</sup>, -хуйц<sup>2</sup>” нөхцөл нь -х, -сан, -аа нөхцөлүүдийнхээ адил үйлийн цагийг тодорхой заадаггүй нь харагдаж байна. Мөн -даг нөхцөлийн адил үйлийн байдал заахгүй байна. Энэ нь япон хэлэнд ч мөн адил байна. Жишээлбэл:

Өвгөн Гончиг, хуучин хэвээрээ үнэмшмээр царай гаргаж инээмсэглэн үнэхээр байсан юм гээд хэд хэд ханиалгаж, эрт дээр эзэрхэг засгийн үед яах аргагүй айхтар чөтгөртэй байсан юм давтаж хэлэв. (Ч.Ойдов, “Чөтгөртэй бууц” 390-р тал)

ゴンチグ老人は顔色も変えず、信用できるような顔をしてほほえみ、「本当にいたよ」 /итгэж чадмаар/

といい、何度もせき払いをして、「昔、清の時代の頃、まぎれもなく恐ろしい幽霊がいた」と繰り返し話した。

Харин ч улмаар итгүүлбэл дээр гэж үзэх тул, Ээ тийм ээ энэ жилдээ ирэхгүй, хойтон ирнэ гэж өвгөний чихэнд дуулдахуйц чанга өгүүлээд дараа нь уг явдлыг нам дуугаар нэг нэгэнгүй ярин халаглана. (Д.Намдаг. “Үрэгдсэнийг хүлээгч”. х.204)

「もちろん、来年は帰って来るよ。今年来られなかったんだから、必ず」二人はつとめて快活に、年寄りによく聞こえるように大声で語りかけた。そしてその後、空しく嘆息(たんそく)/сонсогдохоор/するのだった。

2. “-маар, -мээр, -моор, -мөөр” нөхцөлийн цагийн холбогдол нь хойно орсон туслах үйл үгийнхээ цагийн нөхцөлөөр тодорхойлогдоно гэж үзсэн эрдэмтэдтэй санал нийлж байна.

Жишээлбэл: Энэ яагаад дандаа янаг амрагийн үгтэй холилдох болов гэж бодохоос босон харайж нөхрийнхөө дэргэд очмоор байлаа. (МУЗД. 36-р боть, х.305)

これを聞いたニヤマーは、その語調がまったく愛そのものになっている、と思われてきたので、跳ね起きて、夫のもとへ飛んで行こうとした。/очьё гэж байлаа/

Пэрлээ сая ухаан орж, инээд ч хүрэх шиг, дэргэд хүн байсан бол ичмээр санагдлаа. (Ч.Ойдов. “Чөтгөртэй бууц” х.390)

ペルレーもやっとなれに返り、笑いたいような、そばにだれかがいたら恥ずかしいよう /ичгүүртэй юм шиг/な気持ちであった。

3. “-хуйц, -хүйц” нөхцөлийн үйлийн хир хэмжээ заах утга нь япон хэлэнд ч мөн адил байна. Жишээлбэл:

Он удтал айл нутаглаагүй тэр газар, одоо зохистой дулаан өвөлжөө элбэг сайхан бэлчээртэй авч, усгүй, харин тавиад жилийн өмнө айл өвөлждөг, хүрэлцэхүйц устай худаг байжээ. (Ч.Ойдов. “Чөтгөртэй бууц”. х.388)

長年、アイル(いくつかの家の集団)が居住していないその場所は、現在では、快適で暖かな冬営地に適し、良質の豊かな牧草地であるが、水がない。しかし、五十年ほど前には、アイルが冬営していたし、充分なほどの水がある井戸があった。/хангалттай хэмжээний/

4. Өгүүлбэрт орох байрлал, үүргээрээ үйлт нэрийн бусад бүтээврүүдтэйгээ адил байна. Иймээс түүний хэлзүйн утга, улмаар ер нь үйлт нэрийн нөхцөлүүдийг нарийвчлан судлах хэрэгтэй гэж үзэж байна.

## **НОМ ЗҮЙ**

1. Ш.Лувсанвандан. Орчин цагийн монгол хэлний бүтэц - "Монгол хэлний үг нөхцөл хоёр нь". Уб., 1968
2. П.Бямбасан. Орчин цагийн монгол хэлний үйл үгийн хэв байдал. ХЗХ, 8 боть, Уб., 1970
3. Орчин цагийн монгол хэлний үгзүйн байгуулал. Уб., 1987, Ред. Ш.Лувсанвандан.
4. Озава Шигэо. Монгол хэлийг дөрвөн гарагт. Токио., 1986
5. ШУА. Орчин цагийн монгол хэл зүй. Уб., 1966
6. МУБИС. Орчин цагийн монгол хэл. Уб., 2008
7. 庵(いおり) 功雄(いさお) 「新しい日本語学入門言葉の仕組みを考える」 東京 2001年
8. 益岡隆志(ますおかたかし) ・ 田窪行則(たくぼいくのり) 共著「基礎日本語文法」くろしお出版 1992年

## **Ашигласан хэрэглэгдэхүүн**

1. Т.Мацуда, Х.Хасуми, Ш.Арай. Малгайтай чоно - "Монголын шилдэг өгүүллэг". Кобунша хэвлэлийн газар. Токио хот., 1984.
2. Монголын уран зохиолын дээжис 108. 22-р боть., Ч.Лодойдамба. Уб., 2005.
3. Монголын уран зохиолын дээжис 108. 38-р боть., Л.Түдэв. Эрхий дарам зай. Уб., 2006.
4. Монголын уран зохиолын дээжис 108. 9-р боть., Д.Нацагдорж. Шувуун саарал. Уб., 2005.
5. Монголын уран зохиолын дээжис 108. 60-р боть., Ч.Лхамсүрэн. Хүрэн морь. Уб., 2006.
6. Д.Төмөртогоо. Монгол-Англи-Япон толь. Токио., 1979.

## ОБ ОФИЦИАЛЬНО-ДЕЛОВОМ СТИЛЕ КАЛМЫЦКОГО ЯЗЫКА XVIII ВЕКА

Наличие официальной переписки в системе управления Калмыцкого ханства XVIII века дает определенное представление об уровне экономики, социальных отношений и культуры калмыцкого общества того времени.

Деловая переписка в Калмыцком ханстве сначала велась на старописьменном монгольском языке, а позже - на старописьменном калмыцком языке (тодо бичиг «ясное письмо»). В XVIII веке деловая переписка на «тодо бичиг» достигла наивысшего расцвета. Калмыцкие ханы и нойоны использовали «бичиг» для постоянных связей с центральной и местной Российской властью, для внутреннего управления своими владениями, а также и для контактов с соседними народами. Свидетельством тому являются сотни официально-деловых писем калмыцких ханов XVIII века и их современников, которые отложились в Национальном архиве Республики Калмыкия (сокращенно - НАРК). Основным жанром—официально-делового стиля калмыцкого языка в Калмыцком ханстве XVIII в. был «бичиг» (письмо). Как жанр «бичиг» - это явление древнее и сложное. Возникновение этого жанра у монголов относится к XI- XIII вв. Например, письмо монгольского ильхана Аргуна французскому королю Филиппу IV датируется 1289 годом [1: с. 152], а другое его письмо в адрес римского папы Николая IV датируется 1290 годом [1: с.154]; письмо монгольского ильхана Ульджейту французскому королю Филиппу IV датируется 1305 годом [1: с.156].

21. пятеры ножницы; три зеркала, пять чашь, четыре
22. ве[д]ра, о[д]ну саблю, два дротика, семь тушь
23. бараньего мяса, о[д]на волчьа шкура, двека[л]мы
24. цкие чаши[ч]ки, о[д]на бумажная рубаха, одне
25. сапоги, четыре парь весель, шесть бечевь
26. веревакь, пять буроць, два[д]цать пять
27. лубковь, двои чулки бумажны, одинь ковшь,
28. того ради прошу вась вышписанное о[т]ыска[вь]
29. во[з]вратить вчемь навань вернаго јбольшаго
30. брата благонадежна остаюсь, 1741 году
31. зимнего перьваго м[еся]ца 30 [го] писано
32. уписма печать красная,
33. Переводи[л] яковь Самсоно[вь]
34. Посему о[т]ветствовано и къ полков
35. Нику Кольцову писано 30 ноября
36. 1741. году, Иприто[м] снего прило
37. жена копия,

В Калмыцком ханстве XVIII в. порой возникали сложные правовые отношения между различными группами калмыцких владельцев. Часто такие отношения, вызывали страх и беспокойство за своих близких. Ниже мы приводим одно из таких писем хана Дондук Омбы: *«Причина тисьма, адресованного большому другу, старшему брату, астраханскому коменданту. Я раньше вам писал, что тогда, летом, четыре табуна захватили люди Донгруб Раши и Галдана. В итоге до сих пор [табуны] не вернули. В настоящее время я по указу императрицы направляюсь на Кубань во главе объединенного войска. 23 числа этого месяца я выступлю в поход. В будущем, если вы в состоянии взять на себя такую ответственность, что мои владения не будут подвергаться разбойным нападениям со стороны воровского люда Донгруб Раши и Галдана, то я выступлю в поход со всем своим войском. Если вы не сможете взять на себя такую ответственность, то я войско разделю на две части. Буду вынужден одну часть оставить в своих владениях для безопасности. В течение пяти дней дайте мне разьяснение. Услышав ваш ответ, я написал императрице и послал*

*письмо равному вам [по чину] Беклемишеву». (НАРК, ф.36, оп.1, д.82, л.188; 1736 г.)*


«Производственные» ситуации позволяют не только классифицировать письма по содержанию, но и выделить в официально-деловом стиле калмыцкого языка XVIII века подстили (собственно официально-деловой, юридический и дипломатический), а также жанровые виды «бичиг» (зарлиг бичиг «указ хана», тамһа бичиг «официальное письмо», андһарийин бичиг «письмо-клятва», бичиг «простое письмо» и т.п.).


## ЛИТЕРАТУРА

1. Mongolian Monuments in Uighur- Mongolian Script (XIII- XVI Centuries)/ Introduction, Transcription and Bibliography. Edited dy D. Tumurtogoo With the Collaboration of G. Cecegdari Institute of Linguistics, Academia Sinica 2006. p. 722.
2. Калмыцко-русский словарь. Хальмг-орс толь. М.: Издательство «Русский язык», 1977. с.764.
3. Ожегов С.И. и Шведова Н.Ю. Толковый словарь русского языка М.: Азбуковник, 2000. с.939.
4. Сусеева Д.А. Письма хана Аюки и его современников (1714-1724 гг.): опыт лингвосоциологического исследования. Элиста: АПП «Джангар», 2003. с.384.



**Образец калмыцкого письма XVIII века и соответствующего  
ему русского перевода XVIII века  
(Письмо Чагдоржапа, старшего сына хана Аюки).**







**МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ГАВЬЯАТ  
ЗҮТГЭЛТЭН, ХЭЛ БИЧГИЙН УХААНЫ ДОКТОР,  
ПРОФЕССОР БУХАТЫН БАЗЫЛХАН**

**(1932-2012)**

Бухатын Базылхан нь 1932 онд Баян-Өлгий аймгийн Цэнгэл суманд төрсөн. Монгол Улсын Их Сургуулийг 1960 онд дүүргэж, 1960-1994 онд ШУА-ийн Хэл Зохиолын Хүрээлэнд эрдэм шинжилгээний туслах, ахлах, тэргүүлэх ажилтнаар ажиллаж байв. Тэрбээр 1994-1999 онд Казахстаны ШУА-ийн урилгаар Дорно Дахин Судлалын Хүрээлэнд эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтнаар уригдан ажилласан бөгөөд Казахстанд монгол судлалыг хөгжүүлэхэд зохих хувь нэмрээ оруулсан юм. Үүнийхээ дараагаар эх орондоо буцан ирж, Монгол Улсын ШУА-ийн Баян-Өлгий аймаг дахь Нийгэм-эдийн засгийн судалгааны төвийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтнаар насан эцэслэлтээ үр бүтээлтэй ажиллаж байлаа.

Б.Базылхан нь 1975 онд Казахстаны Алматы хотноо «Монгол казах хэлний харьцуулсан түүхэн хэлзүй» сэдвээр хэл бичгийн ухааны дэд эрдэмтэн, 1993 онд БН Казахстан Улсын Алматы хотноо «Монголын казахуудын хэл ба Алтай хэлний хамаадлын асуудал» сэдвээр хэл бичгийн ухааны докторын зэрэг хамгаалжээ. 2007 онд Монгол Улсын Шинжлэх Ухааны Гавьяат Зүтгэлтэн цолоор шагнуулсан байна.

Б.Базылхан бол манай ахмад эрдэмтдийн залгамж халаа болон Монгол Судлалын салбарт хүч түрэн орж, монгол хэл судлал, казак судлал, эртний орхон бичиг судлал, эртний түрэг хэл судлал, алтай судлалын чиглэлээр хойч үеийнхэндээ судалгааны арвин өв үлдээж, Монгол Улсын казак иргэдийн монгол хэлний мэдлэгийг дээшлүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан нэрт сурган хүмүүжүүлэгч, алдартай эрдэмтэн хүн байлаа.


Монгол Улсын Их Сургууль дөнгөж төгссөн залуу судлаач тухайн үеийнхээ МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны 1963 оны 176-р тогтоолын заалтыг хэрэгжүүлэх үүднээс “БНМАУ-ын их дээд сургуулиудад үзэх монгол хэлний нэг тогтолцоо бүхий сурах бичигтэй болгох зорилгоор...” зохиогдсон “Орчин цагийн монгол хэлзүй (УБ., 1966)”-д “Үйл үгийн ерөнхий ойлголт, үйл үг бүтэхүй, үгүйсгэх эс үгүйсгэх үйл үг, тусах ба эс тусах үйл үг, үйл үгийн хэв байдал, захирах хүсэх үйл үг, цаг заах үйл үг”-ийн тухай хэсгийг бичжээ. Хэл бичгийн ухааны дээд боловсролтой болоод төдий л удаагүй (таван жил гаруйхан хугацаанд), эрдэм шинжилгээний дадлага туршлага төдий гүн суугаагүй үедээ монгол хэлний үгсийн аймгийн системд гол байр эзэлдэг төдийгүй монгол өгүүлбэрийн “амин сүнс” болсон үйл үгийн талаар академик хэлзүйд бичнэ гэдэг энэ хүний эрдэм судлалын ажлын гараа ямар байгааг бидэнд төвөггүй илтгэх мэт.

Түүний нийтлүүлсэн бүтээлийн жагсаалтаас үзэхүл суурь судалгааны шинжтэй гэхэд огтхон ч хэтрүүлэг болохгүй дээрх хэлзүйг бичиж байх үедээ буюу 1962-1964 онуудад Хэл зохиолын хүрээлэнгээс манай улсын нутагт буй казакчуудын хэл аялгууг судлах зорилгоор Баян-Өлгий аймгийн нэлээд хэдэн суманд ажилласан шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд оролцож, энэ

8. Бұхатұлы Базылхан //Қазақ тілі энциклопедиясы. -Алматы,1997. 54 нүүр
9. Құрметхан Мұхамедиұлы. Моңғолиядағы қазақ этникалық тобының қалыптасуы мен дамуы. -Улаанбаатар,1997. -15 нүүр
10. Жанпейісов Е. Моңғол қазақтарының тілін зерттеуші // ҚР ҰҒА хабарлары. Тіл, әдебиет сериясы. -Алматы, 1999. -№5. -44-47 нүүр
11. Базылхан Б. // Қазақстан энциклопедиясы. - Алматы, 2000. -2-том. -148 нүүр

Монгол улсын шинжлэх ухааны гавьяат  
зүтгэлтэн, академич Л.Болд

Ерөнхий редактор Л.Болд, хариуцлагатай редактор  
Б.Түвшинтөгс. “Монголын Алтай судлал”.  
Уб., 2011. “Бэмбисан” хэвлэх үйлдвэр.  
B5-301 х. ISBN 99962-3-099-8



“Монгол хэл бусад хэлтэй хэрхэн холбогдох нь” хэмээх цувралын энэ удаагийн дугаарт монголын үе үеийн алтайч эрдэмтдийн туурвин шинжлэх ухааны эргэлтэд оруулсан бүтээлүүдийг тухайл-

бал академич Б.Ринчен, А.Лувсандэндэв, Д.Төмөртоогоо, Л.Болд, доктор, профессор Б.Базылхан, Б.Сумьяабаатар, Ц.Шагдарсүрэн, доктор (Ph.D) Б.Баасанбат, Ц.Багтулга, М.Баярсайхан, Б.Буянтогтох, Г.Жамбалсүрэн, Л.Мишиг, Э.Пүрэвжав, Б.Түвшинтөгс, М.Ууганбаяр зэрэг эрдэмтэн, судлаачдын алтай хэлний ерөнхий асуудал хийгээд монгол-түрэг, монгол-манж, монгол-япон, монгол-солонгос хэлний харьцааны талаар болон эдгээр хэлтнүүдийн бичиг үсгийн талаар хийсэн судалгааг дээжлэн оруулсан. Монгол хэлийг алтайн бусад хэлтэй харьцуулан түүхчлэн судлах, эх хэлнийхээ түүх, бүтцийг зөвөөр ойлгон тайлбарлахад энэхүү бүтээл бага боловч тус болж чадна хэмээн үзжээ.